





# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД



DDC  
305.90816'021  
X-546

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,  
Засгийн газрын III байр  
<http://www.nso.mn>  
И-мэйл: [nso@magicnet.mn](mailto:nso@magicnet.mn)

НҮБ-ийн Хүн амын сангийн санхүүжилтээр хэвлэв.  
Энэхүү ном нь англи хэл дээр хэвлэгдэх болно.

**ИНТЕРПРЕСС** Утас: 312656, 312616  
ХЭВЛЭЛИЙН КОМПАНИД  
ХЭВЛЭВ.

ISBN 978-99929-2-147-1



МОНГОЛ УЛСЫН  
УНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО**

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД**

Улаанбаатар хот  
2011 он



## АГУУЛГА

Сэдэвчилсэн судалгаа бичихэд оролцогчид .....	iii
Хүснэгт, зургийн жагсаалт .....	iv-v
Хавсралт хүснэгтийн жагсаалт .....	vi
ӨМНӨХ ҮГ .....	1
УДИРТГАЛ .....	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ, ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ .....	13
1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр .....	15
1.2. Хүн ам зүйн үзүүлэлтүүд .....	18
1.3. Байршил, шилжих хөдөлгөөний төлөв .....	29
ХОЁРДУГААР БҮЛЭГ.	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖ БАЙДАЛ .....	33
2.1. Боловсрол, бичиг үсгийн мэдлэг, сургуульд хамрагдал .....	35
2.2. Эдийн засгийн идэвх, ажил эрхлэлт .....	40
2.3. Интернэт, гар утасны хэрэглээ .....	45
ГУРАВДУГААР БҮЛЭГ.	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ШИНЖ БАЙДАЛ, АХУЙН НӨХЦӨЛ .....	47
3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, бүтэц .....	49
3.2. Орон сууцны төрөл, зориулалт ба эзэмшлийн байдал .....	50
3.3. Ахуйн нөхцлийн зарим үзүүлэлт .....	53
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	59
Дүгнэлт .....	61
Зөвлөмж .....	62
НОМ ЗҮЙ .....	64
ХАВСРАЛТ .....	65

## СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

### НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

**Баатаржавын Нарантулга**

Удирдлагын академийн Нийгмийн удирдлагын тэнхмийн ахлах багш

### ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

**Цэнджавын Бадрах**

Эдийн засагч

ҮСХ-ны MNG4P103 төслийн зөвлөх

**Жигжидсүрэнгийн Ядамсүрэн**

Санхүү-Эдийн засагч

Эдийн засгийн ухааны доктор, профессор

### ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

**Жаргалсайханы Цогзолмаа**

Эрүүл мэндийн эдийн засагч

ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010 он .....	5
Хүснэгт 1.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрээр, 2010 он .....	7
Хүснэгт 1.3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хот, хөдөө, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хувиар, 2010 он .....	7
Хүснэгт 1.4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, насны бүлэг, сонгосон үзүүлэлт, хувиар, 2010 он.....	8
Хүснэгт 1.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хүйсийн харьцаа, насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010 он .....	11
Хүснэгт 1.6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хүйсийн харьцаа, насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он .....	12
Хүснэгт 1.7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, үндэс угсаа, хувиар, 2010 он .....	13
Хүснэгт 1.8.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, үндэс угсаа, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	13
Хүснэгт 1.9.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, сонгосон үзүүлэлт, гэр бүлийн байдал, хувиар, 2010 он .....	15
Хүснэгт 1.10.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, шашин шүтлэг, хүйс, хувиар, 2010 он .....	16
Хүснэгт 1.11.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хувиар, 2010 он .....	17
Хүснэгт 1.12.	Суурин хүн ам, хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, аймаг нийслэлээр, 2010 он.....	19
Хүснэгт 2.1.	Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, хүйс, хувиар, 2010 он .....	22
Хүснэгт 2.2.	Зургаа, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, хувиар, 2010 он .....	24
Хүснэгт 2.3.	6-29 насны хөгжлийн бэрхшээлтэй, хүн амын тоо, сургуульд хамрагдал, насны бүлэг, хүйс, хувиар, 2010 он .....	25
Хүснэгт 2.4.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, ажил эрхэлдэг эсэх, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, хувиар, 2010 он .....	27
Хүснэгт 2.5.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, ажил эрхлэлтийн статус, хувиар, 2010 он .....	29
Хүснэгт 2.6.	Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, ажил эрхлээгүй шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, хувиар, 2010 он .....	30
Хүснэгт 2.7.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, эдийн засгийн идэвх, сонгосон үзүүлэлт, хувиар, 2010 он .....	31
Хүснэгт 2.8.	Зургаа, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, гар утас, интернэтийн хэрэглээ, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, хувиар, 2010 он .....	32
Хүснэгт 3.1.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, өрхийн ам бүл, хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хувиар, 2010 он .....	34
Хүснэгт 3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, сууцны төрөл, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	35
Хүснэгт 3.3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, сууцны зориулалт, хувиар, 2010 он .....	35
Хүснэгт 3.4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, усан хангамжийн төрөл, байшингийн төрөл, хувиар, 2010 он .....	38
Хүснэгт 3.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	38
Хүснэгт 3.6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, байшинд амьдардаг өрхийн тоо, байшингийн төрөл, халаалтын эх үүсвэр, хувиар, 2010 он .....	39

## ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010 он .....	4
Зураг 1.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хот, хөдөө, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хувиар, 2010 он .....	5
Зураг 1.3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он .....	6
Зураг 1.4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хувиар, 2010 он .....	6
Зураг 1.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, насны бүлгээр, 2010 он .....	8
Зураг 1.6а.	Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын нас, хүйсийн суварга, 2010 он .....	9
Зураг 1.6б.	Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын нас, хүйсийн суварга, 2010 он .....	9
Зураг 1.7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010 он .....	10
Зураг 1.8.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он .....	10
Зураг 1.9.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хүйсээр, 2010 он .....	11
Зураг 1.10.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, үндэс угсаагаар, 2010 он .....	12
Зураг 1.11.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, гэр бүлийн байдлаар, 2010 он .....	14
Зураг 1.12.	Арван тав, түүнээс дээш насны суурин ба хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, гэр бүлийн байдлаар, хувиар, 2010 он .....	14
Зураг 1.13.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, гэр бүлийн байдал, насны бүлэг, хувиар, 2010 он .....	15
Зураг 1.14.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, шашин шүтлэгээр, 2010 он .....	16
Зураг 1.15.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хувиар, 2010 он .....	18
Зураг 1.16.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хот, хөдөөгөөр, 2010 он .....	18
Зураг 1.17.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, төрсөнөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцсон эсэхээр, 2010 он .....	19
Зураг 1.18.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, төрсөнөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцсон эсэх, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хувиар, 2010 он .....	20
Зураг 2.1.	Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, боловсрол, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он .....	21
Зураг 2.2.	Арав, түүнээс дээш насны суурин ба хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, боловсролын төвшин, хувиар, 2010 он .....	22
Зураг 2.3.	Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, боловсролын төвшин, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	23
Зураг 2.4.	2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдалт, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	24
Зураг 2.5.	6-29 насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, сургуульд хамрагдалт, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	26
Зураг 2.6.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, эдийн засгийн идэвхээр, 2010 он .....	26
Зураг 2.7.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, боловсролын төвшин, хувиар, 2010 он .....	28
Зураг 2.8.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хүйс, хувиар, 2010 он .....	28
Зураг 2.9.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, ажил эрхлээгүй шалтгаан, хувиар, 2010 он .....	29
Зураг 2.10.	Зургаа, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, гар утас, интернэтийн хэрэглээгээр, 2010 он .....	31

Зураг 2.11.	Хөгжлийн бэрхшээлтэй 6, түүнээс дээш насны хүн амын тоо, гар утас, интернэтийн хэрэглээ, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	32
Зураг 3.1.	Монгол Улсын нийт өрхийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор, 2010 он .....	33
Зураг 3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, хувиар, 2010 он .....	33
Зураг 3.3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, сууцны төрлөөр, 2010 он .....	34
Зураг 3.4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, сууцны эзэмшлээр, 2010 он .....	36
Зураг 3.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, сууцны эзэмшил, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	36
Зураг 3.6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, сууцны эзэмшил, зориулалт, хувиар, 2010 он .....	37
Зураг 3.7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, усан хангамжийн төрлөөр, 2010 он .....	37
Зураг 3.8.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн тоо, цахилгааны эх үүсвэрээр, 2010 он .....	38
Зураг 3.9.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, халаалтын эх үүсвэрээр, 2010 он.....	39
Зураг 3.10.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, байшинд амьдардаг өрхийн тоо, бие засах газартай эсэх, хувиар, 2010 он .....	40
Зураг 3.11.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, хог, хаягдлаа зайлуулдаг хэлбэрээр, 2010 он .....	40
Зураг 3.12.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй байшинд амьдардаг өрхийн тоо, хатуу хог хаягдлаа зайлуулдаг хэлбэр, хувиар, 2010 он .....	41

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хавсралт хүснэгт 1.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он .....	46
Хавсралт хүснэгт 2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл, байршил, аймаг, нийслэлээр, 2010 он .....	46
Хавсралт хүснэгт 3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, аймаг, нийслэлээр, 2010 он .....	47
Хавсралт хүснэгт 4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он .....	47
Хавсралт хүснэгт 5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл, насны бүлгээр, 2010 он .....	48
Хавсралт хүснэгт 6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, насны бүлгээр, 2010 он .....	48
Хавсралт хүснэгт 7.	Зургаа, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, боловсролын төвшин, аймаг, нийслэлээр, 2010 он .....	49
Хавсралт хүснэгт 8.	Зургаа, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй боловсролгүй хүн амын тоо, бичиг үсэг мэддэг эсэх, аймаг, нийслэлээр, 2010 он .....	49
Хавсралт хүснэгт 9.	2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, цэцэрлэгт хамрагдалт, байршил, аймаг, нийслэлээр, 2010 он .....	50
Хавсралт хүснэгт 10.	6-9 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, сургуульд хамрагдалт, хот, хөдөө, аймаг, нийслэлээр, 2010 он .....	50
Хавсралт хүснэгт 11.	10-14 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, сургуульд хамрагдалт, хот, хөдөө, аймаг, нийслэлээр, 2010 он .....	51
Хавсралт хүснэгт 12.	15-17 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, сургуульд хамрагдалт, хот, хөдөө, аймаг, нийслэлээр, 2010 он .....	51
Хавсралт хүснэгт 13.	20-29 насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, сургуульд хамрагдалт, хот, хөдөө, аймаг, нийслэлээр, 2010 он .....	52
Хавсралт хүснэгт 14.	Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, эдийн засгийн идэвхийн зарим үзүүлэлт, аймаг, нийслэлээр, 2010 он .....	52
Хавсралт хүснэгт 15.	Зургаа, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, гар утас, интернэтийн хэрэглээ, байршил, аймаг, нийслэлээр, 2010 он .....	53



## ӨМНӨХ ҮГ



Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогодоо “Монгол хүнд эрүүл, саруул аж төрөх, урт наслах, амар тайван байх, түүх, соёлоо хүндэтгэх, бүтээлчээр ажиллах, байнга суралцах, оюун ухаан, авьяас, чадвараа нээн хөгжүүлэх өргөн сонголттой байх таатай орчныг бүрдүүлнэ...” хэмээн зааж, хүн төвт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү стратегийг хэрэгжүүлж, хүний хөгжлийн үндсэн дээр нийгмийн хөгжил дэвшлийг хангах бодлого, үйл ажиллагааны суурь нь хүн амын талаарх үнэн бодит тоо мэдээлэл юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх Үндэсний хэмжээний тоо мэдээллийг цуглуулсан нь цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх, тэдний эрхийг хангах, нийгэмд жирийн иргэдийн адил сурч боловсорч, ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болохыг тэмдэглэж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын мэдээлэлд үндэслэн хийсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” сэдэвчилсэн судалгаанд нийгмийн энэ бүлгийн хүн амын тоо, бүтэц, хүн ам зүйн шинж байдал, түүн дотроо нас, хүйсийн бүтцийн үзүүлэлтийг тодорхойлон дүн шинжилгээ хийжээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлийн байдал, шашин шүтлэг, сургууль/цэцэрлэгт хамрагдалт, боловсролын төвшин, ажил хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн шинж байдлыг өнөөгийн нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан дүгнэхийн сацуу хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн бүтэц, ахуйн нөхцлийн үзүүлэлтийг тусгасан байна.

Уг судалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар Үндэсний хэмжээний тоо баримтыг нэгтгэн толилуулсанаараа энэ чиглэлээр ажилладаг байгууллагууд, эрдэмтэн судлаачид, суралцагчдад суурь мэдээлэл болохуйц бүтээл болжээ.

ҮНДЭСНИЙ СТАСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,  
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН  
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

 С.МЭНДСАЙХАН



## УДИРТГАЛ

### ҮНДЭСЛЭЛ

Хүн ам ба хөгжлийн талаарх бодлого, хөтөлбөр боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэхэд хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн талаарх үнэн бодит тоо мэдээлэл нэн чухал билээ. Хүн амын мэдээллийн хамгийн бодитой эх үүсвэрийн нэг болох “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого”-оор хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаар холбогдох мэдээллийг гаргасан нь бодлогын төвшинд чухал ач холбогдолтой зүйл болж байна.

Эдүгээ хөгжлийн бэрхшээлийг хувь хүнд төрөлхийн болон олдмол хэлбэрээр үүссэн өвчин эмгэг төдийхнөөр бус, илүү нийгмийн шинж чанартайгаар авч үзэх болов<sup>1</sup>. НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” конвенцэд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэдэгт урт хугацааны бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой бөгөөд тийм бэрхшээл нь орчны бусад саадтай нэгдэн нийлж, бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход нь саад учирч байгаа хүмүүсийг хэлнэ”<sup>2</sup> хэмээн заасан байдаг. Цаашлаад хөгжлийн бэрхшээл нь хувь хүний бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болдог бөгөөд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт ажээ<sup>3</sup>. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдал, нийгмийн үйлчилгээг хүртэх байдал, ажил хөдөлмөр эрхлэх боломж зэргийг судлах бодит хэрэгцээ зүй ёсоор тавигдаж байна.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” сэдэвчилсэн судалгаа нь Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн болон ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг цогцоор судлан тодорхойлж, цаашид анхаарах бодлогын асуудлыг тодруулах үндсэн зорилготой. Уг зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нас, хүйсийн бүтэц, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр зэрэг үзүүлэлтийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, бичиг үсгийн мэдлэг, сургууль, цэцэрлэгт хамрагдсан байдлыг аймаг, нийслэл, байршлаар харьцуулан үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн идэвхийг салбараар, ажил эрхлэхгүй байгаа шалтгаан нөхцлийн үзүүлэлтүүдийг бусад үзүүлэлттэй зэрэгцүүлэн дүгнэлт хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн тоо, ам бүлийн бүрэлдэхүүн, орон сууцны ахуйн нөхцлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх;
- Сэдэвчилсэн судалгааны боломжтой үзүүлэлтийг бусад улс орон, бүс нутгийн дундажтай зэрэгцүүлэн үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төр, засгаас цаашид хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрт тусгах бодлогын зөвлөмж боловсруулах; зэрэг болно.

<sup>1</sup> Кристофер Касобон, *Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн оролцоог сайжруулах нь: Өнөөгийн байдал ба хэтийн төлөв*, МУ-ын Засгийн Газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Улаанбаатар, 2010 он, 3 дахь тал

<sup>2</sup> Г.Нарантуяа *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай* НҮБ-ын конвенц гарын авлага, Монгол улсын Хүний эрхийн үндэсний комисс, Раул Фолерогийн анд нөхдийн холбоо байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Европын холбоо, Улаанбаатар, 2008 он, 55 дахь тал

<sup>3</sup> *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээний хөгжил: Дэд бүтэц ба үйлчилгээний хамаарлын судалгаа*, USAID, MercyCorps. Улаанбаатар, 2010 он, 7 дахь тал

## АРГА ЗҮЙ

Судалгааны арга зүйн хувьд статистик өгөгдөл, өөрөөр хэлбэл “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого”-ын тоон мэдээлэлд шинжилгээ хийх аргад голчлон тулгуурласан. Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг хоёрдогч эх сурвалжид шинжилгээ хийх арга зүйг хавсран хэрэглэсэн болно.

Судалгаа нь агуулгын хувьд нэгд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтэц, хүн ам зүйн шинж байдал, хоёрт, нийгэм эдийн засгийн шинж байдал, гуравт, өрхийн шинж байдал, ахуйн нөхцлийг багтаасан бөгөөд эдгээрт хамруулсан үзүүлэлтийг дор харуулав. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, бүтэц, хүн ам зүйн шинж байдал
  - Хөгжлийн бэрхшээлийн тоо, төрөл, хэлбэр
  - Хүн ам зүйн үзүүлэлтүүд: Нас, хүйсийн бүтэц, үндэс угсаа, гэр бүлийн байдал, шашин
  - Байршил, шилжих хөдөлгөөн
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, эдийн засгийн шинж байдал
  - Боловсрол, бичиг үсгийн мэдлэг, сургуульд хамрагдалт
  - Эдийн засгийн идэвх, ажил эрхлэлт
  - Интернет, гар утасны хэрэглээ
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн шинж байдал, ахуйн нөхцөл
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн бүтэц
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн орон сууцны төрөл, зориулалт ба эзэмшлийн байдал
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн ахуйн нөхцлийн зарим үзүүлэлт: Усан болон цахилгаан хангамж, халаалтын эх үүсвэр, бие засах, хог зайлуулах газар зэрэг болно.

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэдэгт Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод хэрэглэсэн “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж ойлгоно”<sup>1</sup> гэсэн заалтыг эш үндэс болгон авч үзэв.

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг төрөлхийн ба олдмол гэсэн ангиллаар тодорхойлсон. Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулсан болно.

Харин хөгжлийн бэрхшээлийн хэлбэр нь бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд чухам ямар байдлаар илэрч байгаатай холбоотой бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар авч үзсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүйсийн бүтэц ямар байгааг тодорхойлоход хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлтийг ашиглав. Хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоогоор тодорхойлогдох бөгөөд 100-аас их бол эрэгтэй хүн амын тоо эмэгтэйчүүдийн тооноос олон, харин 100-аас бага бол эмэгтэй хүн амын тоо эрэгтэй хүн амын тооноос олон байна гэсэн ойлголт юм.

<sup>1</sup> Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай Монгол улсын хууль, Улаанбаатар, 2005 он, 3.1 дэх заалт. <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=6276>

Хүн амын насны бүтцийн шинжилгээнд хүүхдүүд, хөдөлмөрийн буюу идэр насныхан, хөгшид гэсэн үндсэн 3 ангиллыг чухалчлан авч үздэг<sup>1</sup>. Нийт хүн амд хүүхдүүдийн эзлэх хувийн жинг залуу хүн амын хувь, 65, түүнээс дээш насныхны эзлэх хувийн жинг хөгшин хүн амын хувь гэдэг байна.

Голч нас нь хүн амыг насны бүтцийнх нь хувьд яг таллан хувааж байгаа нас юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн насны бүтцийг тодорхойлоход голч насыг ашигласан ба эдгээр хүн амын 50.0 хувь нь голч нас хүртэлх, 50.0 хувь нь голч наснаас ахмад насны хүн ам байгааг илэрхийлнэ.

Ажил эрхлэлт, эдийн засгийн идэвхтэй холбоотой мэдээлэл нь 15, түүнээс дээш насны хүн амд хамаарна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчин гэсэн ойлголт нь тооллогын хугацаанд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүйчүүдийн нийлбэрээр тодорхойлогдоно.

Тооллогоос өмнөх 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд нэгээс дээш цагаар оролцсон иргэдийг ажил эрхэлдэг хүн ам гэсэн ангилалд оруулсан. Харин тооллогоос өмнөх 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцоогүй иргэдийг ажил эрхлээгүй хүн амд хамааруулав.

“Ажил хайж байгаа” гэсэн шалтгаанаар ажил эрхлээгүй, өөрөөр хэлбэл ажил эрхлэхэд бэлэн байгаа хүмүүсийг эдийн засгийн идэвхтэй хүн амын нэг хэсэг болох ажилгүй хүн ам гэж үзэв. Ажилгүйдлийн төвшинг эдийн засгийн идэвхтэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувийн жингээр тодорхойлсон.

---

<sup>1</sup> А. Солонго, Т.Навч, Б.Мөнхжаргал нар, Хүн ам зүйн үндсэн асуудлууд сурах бичиг, НҮБ-ын Хүн Амын Сан, Хүн Амын Сургалт Судалгааны Төв, Улаанбаатар, 2006 он, 25 дахь тал

## Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод хэрэглэсэн зарим ойлголт, тодорхойлолт

№	Ойлголт	Тодорхойлолт
<b>ӨРХ, ХҮН АМ</b>		
1.	Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.
2.	Үндсэн өрх	“Үндсэн өрх” гэж сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг /ордер/, орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.
3.	Хамт суудаг өрх	Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.
4.	Өрхийн тэргүүлэгч	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-аас дээш настай, өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
5.	Өрхийн ам бүлийн гишүүд	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тооллогын үед тухайн өрх айлд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.
<b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД</b>		
6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэнэ.
7.	Төрөлхийн	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
8.	Олдмол	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
9.	Харааны	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
10.	Сонсголын	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
11.	Хэл ярианы	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
12.	Хөдөлгөөний	Биеийнхээ тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.

13.	Сэтгэцийн	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх, ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцооны дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.
-----	-----------	---

**СУУРЬШИЛ**

14.	Байнга суудаг	Тооллогын товын байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүн
15.	Түр эзгүй	Тооллогын товоос өмнө үндсэн засаг захиргааныхаа нэгжээс гадагш 6 сар (183 хоног) хүрэхгүй хугацаагаар явсан хүн
16.	Түр суугаа	Тооллогын товоос өмнө өөр засаг захиргааны нэгжээс ирж, тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүн

**БОЛОВСРОЛ**

17.	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгссөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2010 онд ЕБС-ын 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
18.	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
19.	Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг (1975 он хүртэл) 8 дугаар ангийг (1975-2004 оныг дуустал) 9 дүгээр ангийг (2005 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
20.	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг (2006 он дуустал), 11 дүгээр ангийг (2006 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн
21.	Техникийн болон мэргэжлийн боловсрол	МСҮТ (хуучнаар ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
22.	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
23.	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг мөн энэ ангилалд хамааруулна.
24.	Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
25.	Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших, бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг Бичиг үсэг мэддэггүй гэж үзнэ.

**ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ**

26.	Огт гэрлээгүй	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
27.	Батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
28.	Батлуулаагүй	Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
29.	Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацааг харгалзахгүйгээр Цуцалсан гэж үзнэ.
30.	Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Тусгаарласан гэж үзнэ.
31.	Бэлбэсэн	Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг Бэлбэсэн гэж үзнэ.

#### АЖИЛ ЭРХЛЭЛТ

32.	Ажил эрхэлдэг хүн	Тооллогын товын үед тогтмол ажил эрхэлж байгаа, эсвэл тогтмол ажил эрхэлдэггүй боловч товын өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалинтай ажил эрхэлсэн хүн
33.	Ажилгүй хүн	Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн эсвэл бүртгүүлээгүй, тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүн

#### МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ БА ТОДОРХОЙЛОЛТ

34.	Менежер	Менежер нь засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтанг хамруулна. Тухайлбал, төрийн болон хувийн аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын бүх түвшний дарга, захирал, хууль тогтоогч, төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, бүх түвшний засаг дарга, захирагч, ТББ-ын удирдах албан тушаалтан, менежер гэх мэт.
35.	Мэргэжилтэн	Мэргэжтэн нь мэдлэгийнхээ санг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, тэдгээрийг системтэйгээр заах сургах буюу мэргэжлийн өндөр төвшин шаардсан ажил гүйцэтгэгч байна. Тухайлбал, шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн, эмч, сувилагч, багш, судлаач, бизнесийн болон захиргааны мэргэжилтэн, программ зохиогч, шашны мэргэжилтэн, уран бүтээлч, дуучин, жүжигчин гэх мэт.
36.	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн нь шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хийх судалгаа, практикт хэрэгжүүлэхэд холбогдох техник шинжтэй ажил гүйцэтгэнэ. Тэд уул уурхай, аж үйлдвэр, барилга болон бусад салбарын инженерийн үйл ажиллагаатай холбоотой техникийн болон үйлдлийн арга ажиллагааг хянах, удирдах, тоног төхөөрөмж ажиллуулна. Физик, инженерийн ухааны техникч, уурхай, үйлдвэр болон барилга угсралтын байцаагч, технологи процесс, чанар шалгагч, амьд ертөнц судлах ухааны техникч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн, усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч гэх мэт.
37.	Контор, үйлчилгээний ажилтан	Тодорхой асуудалд хамаарах мэдээллийг тэмдэглэх, эмхлэх, хадгалах, тооцоолон бодох, сэргээн засварлах ба мөнгөний гүйлгээ хийх, аялал жуучлал зохион байгуулах, мэдээлэл авах, хүсэлт тавих, уулзалт товлох зэрэг туслах шинжтэй олон төрлийн үүргийг гүйцэтгэнэ. Компьютерийн операторч, үйлчилгээний туслах ажилтан, тооцоолол, материал, тоо бүртгэлийн ажилтан, конторын бусад туслах ажилтан гэх мэт.



38.	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Үйлчилгээ, худалдааны ажилтан нь аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах юмуу хууль бус үйлдэл, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, мухлагаар бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Хувийн үйлчилгээний ажилтан, худалдааны ажилтан, хувь хүн асрах ажилтан, хамгаалах үйлчилгээний ажилтан гэх мэт.
-----	--------------------------------	---

39.	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан нь үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр бүлийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж, үржүүлнэ. Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан, зах зээлийн баримжаатай ой, загас агнуурын аж ахуйн мэргэшсэн ажилтан, өрхийн хэрэгцээний шинжтэй фермерч, загасчин, анчин болон түүн цуглуулагч гэх мэт.
-----	-----------------------------------	---

**АЖИЛТАН**

40.	Үйлдвэрлэл, барилга, гар урлал,	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан нь барилга барих, арчлах, металл хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хийх, тааруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэх салбарт мэдлэг, ур чадвараа хэрэглэнэ. Металл, машин, механизм, түүнтэй холбогдох бусад мэргэжлийн ажилтан, гар урлал, хэвлэлийн ажилтан, цахилгаан болон цахим техникч, хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч гэх мэт.
-----	---------------------------------	--

**ХОЛБОГДОХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

41.	Суурин төхөөрөг, машин механизмын	Хөдөө аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийг биечлэн жолоодох эсвэл зайнаас буюу алсын удирдлагаар удирдаж ажиллуулах, хянах, галт тэрэг, хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, ажиллуулах, эд анги, хэсгүүдээс бүрдсэн бүтээгдэхүүнийг заавар, журам, стандарт, шаардлагын дагуу угсрах ажил эрхэлнэ. Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч, жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч гэх мэт.
-----	-----------------------------------	--

**ОПЕРАТОРЧ, УГСРАГЧ**

42.	Энгийн ажил, мэргэжил	Энгийн ажил эрхлэгч нь өдөр тутмын, байнга давтагдах шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчлон биеийн хүчний ажил эрхэлнэ. Цэвэрлэгч, туслагч, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил, уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил, хүнс бэлтгэлийн туслах ажил, гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил, бусад энгийн ажил гэх мэт.
-----	-----------------------	--

43.	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Зэвсэгт хүчний офицерийн цол бүхий Монгол Улсын Зэвсэгт хүчний зохих албан тушаалд цэргийн алба хаахыг офицерийн алба гэнэ. Зэвсэгт хүчний офицер нь төрөл бүрийн энгийн ажил, мэргэжилд байдаг ижил төстэй үүрэг гүйцэтгэж болно. Энэ бүлэгт Зэвсэгт хүчинд алба хааж байгаа дунд офицер, ахлах офицер, дээд офицерийн нийт бие бүрэлдэхүүн багтана.
-----	-------------------------------	---

**ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

44.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Энд мал, амьтны болон таримал, байгалийн ургамлын нөөцийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа орно. Үүнд: газар тариалан эрхлэх, мал, амьтныг өсгөх, үржүүлэх, түүний ашиг шимийг авах; загас барих; ан агнуур; ойжуулалт, мод бэлтгэл; фермерийн аж ахуйн үйл ажиллагаа зэрэг хамаарна.
-----	---	---

45.	Уул уурхай, олборлолт	Байгалийн хатуу (нүүрс, хүдэр), шингэн (нефть) эсвэл хий (байгалийн хий) зэрэг эрдэс баялгийг олборлох уул уурхайн үйл ажиллагаа багтана. Олборлох үйл ажиллагаа нь далд эсвэл ил уурхай, далайн ёроолын уурхай гэх мэт уурхайгаас төрөл бүрийн аргаар гаргаж авах үйл ажиллагаа байж болно.
46.	Боловсруулах үйлдвэрлэл	Боловсруулах үйлдвэрлэл нь түүхий эд, материалыг физик болон химийн аргаар хувиргаж шинэ бүтээгдэхүүн үүсгэх үйл ажиллагаа юм. Боловсруулах үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүн нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, уул уурхай, олборлолтын бүтээгдэхүүнүүд орно. Мөн бусад боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох түүхий эд материал, бодис эсвэл бүтээгдэхүүнийг хувиргахад орох түүхий эд байна. Барааг шинэчлэх, сэргээн босгох, өөрчлөх үйл ажиллагаа нь ихэвчлэн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа байна.
47.	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Энэ салбарт дэд бүтцийн /сүлжээ/ шугам хоолойгоор дамжуулан цахилгаан эрчим хүч, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах үйл ажиллагаа хамрагдана. Түүнчлэн нэгдсэн сүлжээгүй орон нутгийн чанартай барилга байгууламжийн бие даасан эх үүсвэр бүхий цахилгаан, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах, түгээх ажиллагаа мөн багтана.
48.	Ус хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	Энэ салбарт өрхийн болон үйлдвэрийн хатуу эсвэл хатуу бус, бохирдсон талбай зэргийн хог, хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулах явцтай холбоотой үйл ажиллагаа багтана. Хог хаягдал, бохир ус боловсруулах үйл ажиллагааны үр дүнд ариутгасан эсвэл шинэ бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагаа байж болно. Усан хангамжийн үйл ажиллагаа нэгтгэгдэн энэ салбарт орно. Ус хангамжийн үйл ажиллагаа ихэнхдээ бохир усыг цэвэрлэх, боловсруулах үйл ажиллагаатай холбоотой байдаг ба аж ахуйн нэгжүүд эдгээр үйл ажиллагааг хамтруулан хийдэг байж болно.
49.	Барилга	Их барилга угсралт болон иргэний инженерийн байгууламж, байшин, барилгыг угсрах болон мэргэжсэн барилгын үйл ажиллагаа энэ салбарт багтана. Энд шинэ ажил, барилга засвар, нэмэлт болон жижиг засвар, угсармал барилга, барилгын талбай, түр зуурын чанартай барилга угсрах үйл ажиллагаа орно.
50.	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Бүх төрлийн Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, тухайлбал, хувирган өөрчлөхгүй худалдаалах, барааг худалдан авах явцад гарах үйлчилгээ мөн машин, мотоциклийн засвар, үйлчилгээ хамаарна.
51.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Хий дамжуулах хоолой, төмөр зам, авто зам, усан ба агаарын тээврийн тогтсон хуваарьтай, хуваарьгүй ачаа ба зорчигч тээвэрлэлт, агуулах, ачаа, тээшийн үйлчилгээ, автомашины зогсоол, гарааш зэрэг үйл ажиллагаа орно. Түүнчлэн тээврийн хэрэгслийг ажиллуулагч хүнтэй нь түрээслэх үйл ажиллагаа энэ салбарт багтана. Мөн шуудан, холбооны үйл ажиллагаа орно.
52.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Түр зуурын зочин, бусад аялагчдыг богино хугацаагаар байр сууцаар хангах, шууд хэрэглэх зориулалттай хоол хүнс, ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа орно. Энэ салбарт тусгагдаж байгаа нэмэгдэл үйлчилгээний хэмжээ, төрөл нь нилээд их байна.
53.	Мэдээлэл, холбоо	Энэ салбарт мэдээлэл, соёлын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт, энэ төрлийн бүтээгдэхүүнийг дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа, тухайлбал, холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах болон мэдээллийн үйлчилгээтэй холбоотой бусад үйл ажиллагаа орно.

54.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Даатгалын үйл ажиллагаа, давхар даатгал болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаа, мөн санхүүгийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагааг оруулан санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагааг энэ салбарт орно. Холдинг компани, траст, сан болон санхүүгийн бусад үйл ажиллагаа зэрэг холдинг хөрөнгийн үйл ажиллагаа энэ салбарт багтана.
55.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Энд лизингийн үйлчилгээ олгогчид, агентууд, брокеруудын үл хөдлөх хөрөнгө арилжаалах, үл хөдлөх хөрөнгө түрээслэх, үнэлгээ хийх зэрэг үл хөдлөх хөрөнгийн бусад үйлчилгээ орно. Энэ салбарын үйл ажиллагаа нь төлбөр, гэрээний үндсэн дээр хийгдэж эзэмшигчийн эсвэл лизингээр авсан өмчийг ашиглах үйл ажиллагаа байж болно. Мөн энд эзэмшигчийн эсвэл лизингийн баригдаж байгаа барилга болон барилга, байгууламжийг оруулна. Энэ салбарт үл хөдлөх хөрөнгийн менежерийн үйл ажиллагаа багтана.
56.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Мэргэшсэн мэргэжил, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа энэ салбарт орно. Эдгээр үйл ажиллагаа нь өндөр түвшний сургалт, мэргэшсэн мэдлэг олгох, хэрэглэгчдэд ур чадвар олгох зэрэг байна.
57.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Ерөнхий бизнесийн үйл ажиллагааг дэмжих төрөл бүрийн үйл ажиллагааг энд хамруулна.
58.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Төрийн удирдлагаар хэрэгждэг үйл ажиллагаа орно. Үүнд хуулийн тайлбар, тогтоол ба тэдгээрийн зохицуулалт, тэдгээр дээр суурилсан үйл ажиллагаануудын удирдлага, хууль тогтоох үйл ажиллагаа, татвар, улсын батлан хамгаалах, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа, цагаачлалын үйлчилгээ, гадаад харилцааны үйл ажиллагаа ба засгийн газрын хөтөлбөрүүдийн удирдлагын үйл ажиллагаа зэрэг орно. Мөн энэ салбарт албан журмын нийгмийн хамгааллын үйл ажиллагаа багтана.
59.	Боловсрол	Энэ салбарт бүх шатны, бүх мэргэжлийн боловсролыг өдөр, орой, эгнээ хэлбэрээр анги, танхим, радио, телевиз болон бусад мэдээллийн хэрэгсэл, зайн сургалтаар дамжуулан олгосон боловсролын үйл ажиллагаа орно. Төрөл бүрийн сургалтын байгууллагын албан болон албан бус сургалт багтана. Түүнчлэн насанд хүрэгчдийн боловсрол, бичиг үсэг тайлагдалтын хөтөлбөр зэрэг орно. Мөн бүх насны цэргийн сургууль, академи, хорихын сургууль хамрагдана.
60.	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Энэ салбарт эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа орно. Үйл ажиллагаанд нь эмнэлгийн анагаахын мэргэжилтнүүдэд эмнэлэг болон бусад сургалтын сургагдсан эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанаас эхлэн хүн амыг асрах үйл ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээ болон заавал мэргэжлийн эмнэлгийн ажилтан бус нийгмийн ажилтны үйл ажиллагаа багтана.
61.	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Энэ дэд салбарт өргөн цар хүрээг хамарсан төрөл бүрийн соёлын уулзалт, үзвэр болон олон нийтийг хамарсан сонирхолтой тоглоом наадам багтахын зэрэгцээ амьд үзүүлбэр, музейн үйлчилгээ, мөрийтэй спорт, амралт зугааллыг үйл ажиллагаа хамрагдана.
62.	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Энэ салбарт байгууллагуудын гишүүнчлэлтэй холбоотой үйл ажиллагаа, компьютерын болон хувь хүн, өрхийн хэрэглээний барааны засвар үйлчилгээ орох бөгөөд өмнөх, бүлэг, ангид ороогүй хувь хүнтэй холбоотой төрөл бүрийн бусад үйлчилгээний үйл ажиллагаа орно.
63.	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; Өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	Гэрийн үйлчлэгч, тогооч, зөөгч, цэвэрлэгч, барлаг, шивэгчин, угаагч, цэцэрлэгч, манаач, малчин, ногоочин, байнгын харгалзагч, жолооч, хаалгач, гэрийн хүмүүжүүлэгч, хүүхэд асрагч, гэрийн багш, нарийн бичиг зэрэг ажил, үйлчилгээг айл, өрхөд цалин хөлстэйгээр хийх үйл ажиллагаа орно. Энд зөвхөн өөрийн хэрэглээ, амь зуулгандаа зориулан, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй хэд хэдэн төрлийн бараа болон үйлчилгээ явуулдаг өрх хамрагдана.


64. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа
- Энэ ангид Нэгдсэн үндэстний байгууллага, түүний системийн төрөлжсөн байгууллагууд, бүс нутгийн төлөөлөгчид, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Дэлхийн гаалийн байгууллага, Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Нефть экспортлогч орнуудын байгууллага, Европын холбоо, Европын худалдааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагын үйл ажиллагаа орно. Тухайн улс оронд байрлаж буй дипломат болон консулын төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа нь аль улсыг төлөөлж байгаагаас үл хамааран энэ ангид мөн багтана.

#### ОРОН СУУЦ

65.	Орон сууцны байшин	Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна.
66.	Бие даасан тохилог сууц	Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна.
67.	Сууцны тусдаа байшин	Гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын усан систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.
68.	Оюутан сурагчдын нийтийн байр	Бүх шатны сургуулиудийн оюутан, сурагчдын хамтран амьдрахад зориулагдсан байр
69.	Ажиллагчдын нийтийн байр	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид нийтээр амьдрахад зориулсан байр
70.	Нийтийн зориулалтын бусад байр	Амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, шорон, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байр
71.	Өрөөний тоо	Нийт өрөөний тоонд унтлагын өрөө, амрах болон ажлын өрөө орно.
72.	Сууцны талбай (кв.метр)	Сууцны талбайн хэмжээ нь хүн амьдрах талбай /амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын болон хооллох өрөө/ туслах өрөө, тасалгаа /гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах/-ны талбайн нийлбэр

# НЭГЛҮГЭЭР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ,  
ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ






## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ, ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ

Энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, тэдгээрийн байршил, насны бүлэг, хүйсийн ялгаа, нас, хүйсийн бүтцийг харуулах гол үзүүлэлтүүд, үндэс угсаа, гэр бүлийн байдал, шашин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байршил, шилжих хөдөлгөөний талаар танилцуулж байна.

### 1.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор Монгол улсад нийт 108.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 48.4 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 34.0 хувь нь төрөлхийн, 66.0 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлд өртөх тохиолдол өндөр байгааг харуулж байна.

ЗУРАГ 1.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО,  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН



Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгааны нэг нь осол гэмтэл болж байгаатай холбоотой. Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгийн улмаас нас барсан хүний тоо нийт нас баралтын 16.0 хувийг эзэлж, нас баралтын 3 дахь томоохон шалтгаан болж байна<sup>1</sup>.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоог бэрхшээлийн төрөл, насаар ангилан авч үзэхэд, харьцангуй залуу насныхны дотор төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгджээ. 0-4 насны 4 хүүхэд тутмын бараг 3 нь (73.4 хувь) төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байсан бол энэ тоо цаашид үргэлжлэн буурч, хөгжлийн бэрхшээлтэй 70, түүнээс дээш насныхны 7.6 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд байв (Хүснэгт 1.1).

Харьцангуй ахмад буюу 60, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй 10 хүн тутмын 9 нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байсан нь бусад насныхнаас даруй 63.7 хүртэлх пунктээр өндөр үзүүлэлт юм.


<sup>1</sup> Монгол Улсын статистикийн эмхтгэл 2010, Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар, 2011 он, 373 дахь тал

### ХҮСНЭГТ 1.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн		Олдмол	
			Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>108 071</b>	<b>100.0</b>	<b>36 765</b>	<b>34.0</b>	<b>71 306</b>	<b>66.0</b>
0-4	1 957	100.0	1 436	73.4	521	26.6
5-9	3 068	100.0	2 106	68.6	962	31.4
10-14	4 436	100.0	2 731	61.6	1 705	38.4
15-19	6 390	100.0	3 801	59.5	2 589	40.5
20-24	7 933	100.0	4 236	53.4	3 697	46.6
25-29	8 833	100.0	4 317	48.9	4 516	51.1
30-34	8 988	100.0	4 106	45.7	4 882	54.3
35-39	10 250	100.0	3 883	37.9	6 367	62.1
40-44	11 596	100.0	3 345	28.8	8 251	71.2
45-49	13 551	100.0	2 868	21.2	10 683	78.8
50-54	11 788	100.0	1 832	15.5	9 956	84.5
55-59	6 756	100.0	887	13.1	5 869	86.9
60-64	3 223	100.0	399	12.4	2 824	87.6
65-69	2 690	100.0	318	11.8	2 372	88.2
70+	6 612	100.0	500	7.6	6 112	92.4

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоог байршлаар нь харьцуулан авч үзвэл хотод амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй 10 хүн тутмын 7 нь, хөдөө амьдарч байгаа 10 хүн тутмын 6 нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байв. Энэ нь төв суурин газарт хөгжлийн бэрхшээлд өртөх явдал бага зэрэг илүү байгааг харуулж байна.

### ЗУРАГ 1.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн амын 55.2 хувь, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 57.6 хувийг тус тус эрэгтэйчүүд эзэлж байна. Харин төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд хүйсийн харьцаа ойролцоо буюу 36 762 хүний 18 611 нь эрэгтэйчүүд, 18 151 нь эмэгтэйчүүд байв. Үүнээс харахад, эрэгтэйчүүд гэмтэл, хордлого болон гадны нөлөө бүхий эрсдэлд илүүтэй өртөхийн зэрэгцээ олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байна.




Хөдөлгөөн болон сэтгэцийн эмгэгтэй хүн амын тоо хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 48.3 хувийг эзэлж байгаа нь эдгээр бэрхшээлүүд бусдаас түгээмэл байгааг харуулж байна.

ЗУРАГ 1.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО,  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоог хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл нэгд хөдөлгөөний, хоёрт сэтгэцийн, гуравт хавсарсан болон бусад, дөрөвт харааны, тавд сонсголын, зургаад ярианы эмгэг тус тус орж байна. Өөрөөр хэлбэл, биеийнхээ тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар нь алдагдсан иргэд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгийн өндөр буюу 28.9 хувийг эзэлсэн байна. Энэ нь ярианы бэрхшээлтэй хүн амаас 5.2 дахин, сонсголын бэрхшээлтэй хүн амаас 2.5 дахин тус тус өндөр үзүүлэлт юм.

ЗУРАГ 1.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО,  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээл нь төрөлхийн, эсвэл олдмол байхаас хамааран илрэх хэлбэр ч ялгаатай байв (Хүснэгт 1.2).

Ярианы болон сэтгэцийн хэлбэрээр илэрсэн хөгжлийн бэрхшээл төрөлхийн байх нь олонтаа байна. Тухайлбал, ярианы хөгжлийн бэрхшээлтэй буюу бүрэн хэлгүй 4 хүн тутмын 3 нь төрөлхийн, үлдсэн нэг нь олдмол байдлаар, өөрөөр хэлбэл өвчлөл болон бусад гадаад шалтгааны улмаас хэлгүй болжээ.

### ХҮСНЭГТ 1.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн		Олдмол	
			Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>108 071</b>	<b>100.0</b>	<b>36 765</b>	<b>34.0</b>	<b>71 306</b>	<b>66.0</b>
Харааны	16 631	100.0	5 131	30.9	11 500	69.1
Ярианы	5 999	100.0	4 338	72.3	1 661	27.7
Сонсголын	12 633	100.0	4 875	38.6	7 758	61.4
Хөдөлгөөний	31 265	100.0	8 274	26.5	22 991	73.5
Сэтгэцийн	20 898	100.0	10 864	52.0	10 034	48.0
Бусад	20 645	100.0	3 283	15.9	17 362	84.1

Хараа, сонсгол, хөдөлгөөн болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 60-аас илүү хувь нь эрүүл төрсөн хэдий ч амьдралынхаа явцад харах, сонсох болон тулгуур эрхтний эмгэгтэй болжээ. Ялангуяа, хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 73.5 хувь нь олдмол байдлаар бие махбодийн эмгэгтэй болсон бөгөөд нийт хүн амд осол, гэмтлийн тохиолдол өндөр байгаа нь хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл олдмол байдлаар үүсэхэд нөлөөлж байж болох талтай.

### ХҮСНЭГТ 1.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Үзүүлэлт	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр (Дүнд эзлэх хувь)					
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Харааны	Ярианы	Сонсголын	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Бусад
<b>БҮГД</b>	<b>108 071</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Байршил</b>								
Хот	67 069	62.1	58.8	56.1	62.8	62.7	58.9	68.2
Хөдөө	41 002	37.9	41.2	43.9	37.2	37.3	41.1	31.8
<b>Хүйс</b>								
Эрэгтэй	59 662	55.2	56.8	56.3	55.0	56.6	52.0	55.0
Эмэгтэй	48 409	44.8	43.2	43.7	45.0	43.4	48.0	45.0

Байршлаар авч үзвэл, хөдөлгөөн, сонсгол болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын эзлэх хувь хотод харьцангуй өндөр байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа нь хөгжлийн бэрхшээлийн бүхий л хэлбэрт ажиглагдсанаас гадна хэлбэр тус бүрээр ялгаа багатай байна. Тодруулбал, хараа, сонсгол, хөдөлгөөн гэх мэт хөгжлийн бэрхшээлийн бүх хэлбэрийн тухайд 52.0-56.8 хувийг эрэгтэйчүүд, 43.4-48.0 хувийг эмэгтэйчүүд эзэлсэн байна.

#### 1.2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтүүдэд тэдний нас, хүйсийн бүтэц, үндэс угсаа, гэр бүлийн байдал болон шашин шүтлэгийг хамааруулан авч үзлээ. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 8.7 хувь нь 15 хүртлэх насны хүүхдүүд, 82.7 хувь нь 15-64 насныхан, 8.6 хувь нь 65, түүнээс дээш насны ахмадууд байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн насны бүтцийг Монгол Улсын нийт хүн амын насны бүтэцтэй зэрэгцүүлбэл нийт хүн амд хүүхдүүдийн эзлэх хувь 19.3 пунктээр доогуур, идэр насныхны эзлэх хувь 14.6 пунктээр өндөр, ахмадуудын эзлэх хувь 3.9 пунктээр өндөр байв.

ЗУРАГ 1.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО,  
НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын насны бүтэц нь байршил, хүйсээр авч үзэхэд ялгаа багатай, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрийн хувьд ялгаатай хандлага ажиглагджээ.


ХҮСНЭГТ 1.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ,  
СОНГОСОН ҮЗҮҮЛЭЛТ, ХУВИАР, 2010 ОН

Үзүүлэлт	Бүгд		Насны бүтэц (Дүнд эзлэх хувь)			
	Хүний тоо	Хувь	0-14	15-44	45-64	65+
<b>БҮГД</b>	<b>108 071</b>	<b>100.0</b>	<b>8.7</b>	<b>50.0</b>	<b>32.7</b>	<b>8.6</b>
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	59 662	100.0	8.7	50.4	34.0	6.9
Эмэгтэй	48 409	100.0	8.9	49.5	31.0	10.6
<b>Байршил</b>						
Хот	67 069	100.0	8.1	49.5	33.8	8.6
Хөдөө	41 002	100.0	9.8	50.6	31.0	8.6
<b>Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр</b>						
Харааны	16 631	100.0	11.3	45.9	28.1	14.7
Ярианы	5 999	100.0	20.4	58.4	16.1	5.1
Сонсголын	12 633	100.0	6.1	52.9	29.6	11.4
Хөдөлгөөний	31 265	100.0	8.6	45.2	34.6	11.6
Сэтгэцийн	20 898	100.0	7.7	64.1	25.9	2.3
Бусад	20 645	100.0	6.2	41.7	47.2	4.9
<b>Хөгжлийн бэрхшээлийн төрөл</b>						
Төрөлхийн	36 765	100.0	17.1	64.4	16.3	2.2
Олдмол	71 306	100.0	4.5	42.5	41.1	11.9


Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр ангилан үзвэл ярианы болон сэтгэцийн бэрхшээлтэй хүн амын дунд 45, түүнээс дээш насныхны эзлэх хувь төдийлөн өндөр биш байхад бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын талаас илүү хувь нь энэ насныхан байлаа. Энэ нь яриа болон сэтгэцийн бэрхшээл гол төлөв төрөлхийн байдагтай холбоотой.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 17.1 хувь нь 15 хүртэлх насныхан, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 4.5 хувь нь мөн насныхан байна. Түүнчлэн төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 18.5 хувь нь 45, түүнээс дээш насныхан байсан бол олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд энэ үзүүлэлт 2.8 дахин өндөр байна. Өөрөөр хэлбэл, насны бүтцийн хувьд олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс харьцангуй ахмад насны бүлэгт багтаж байгаа нь дараах зургуудад илүү тодорхой харагдана (Зураг 1.6а, 1.6б).

ЗУРАГ 1.6А. ТӨРӨЛХИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



ЗУРАГ 1.6Б. ОЛДМОЛ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын суварга нь суурь, орой хэсгээрээ нарийн, дунд хэсгээрээ нэлээд өргөссөн, өөрөөр хэлбэл төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амд 20-39 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 46.4 хувийг 15-34 насныхан, эмэгтэйчүүдийн 44.6 хувийг 20-39 насныхан бүрдүүлжээ. Энэ тоо нийт хүн амд 70, түүнээс дээш насны ахмадууд, 10 хүртэлх насны хүүхдүүдийн эзлэх хувиас даруй 40 орчим пунктээр өндөр үзүүлэлт юм.


Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын суваргыг харахад, насны бүлэг ахихын хэрээр тухайн хүн амын тоо нэмэгдэж, 45-54 насанд хамгийн өндөр төвшинд хүрээд эргэж буурсан байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амд 0-9 насны хүүхдүүд 10 хүртэлх хувийг эзэлж байсан бол 10-29 насныхан 17.5 хувь, 45-59 насныхан 37.2 хувь гэх мэтээр хувийн жин нэлээд өөрчлөгджээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч насыг тооцож үзэхэд 40.9 гарсан (Зураг 1.7). Хүн амын насны бүтцийн шинжилгээнд уг үзүүлэлтийн утга 25 ба түүнээс дээш байгаа тохиолдолд насны бүтцийн хувьд “хөгшин”<sup>1</sup> гэж үздэг хандлагатай харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд насны бүтцийн хувьд “хөгшин” гэж хэлж болохоор байна.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 50.0 хувь нь 30 хүртэлх, 50.0 хувь нь 30 ба түүнээс дээш насныхан байгаа нь нийт хүн амтай харьцуулахад 10, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амтай харьцуулахад 16 жилээр тус тус доогуур төвшин юм. Эндээс, тооллого явагдах хугацаанд амьд байгаа төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тэн хагас нь 1980-2010 оны хооронд, үлдсэн хагас нь 1980 оноос өмнө төрсөн гэсэн дүгнэлтийг хийж болно.

<sup>1</sup> Рикардо Ньюперт, ХАССТ-ийн багш судлаачид, Монголын хүн амын нас, хүйсийн бүтцийн өнөөгийн байдал, ирээдүйн хандлага өгүүлэл, Монголын хүн амын сэтгүүл, дугаар 10, 2004 он, 9 дэх тал


ЗУРАГ 1.7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ГОЛЧ НАС,  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын голч нас 40.6, эмэгтэйнх 41.3 байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч насанд хүйсийн ялгаа төдийлөн харагдахгүй байгааг илтгэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын насны бүтэц хөгжлийн бэрхшээлийн хэлбэр бүрээр ялгаатай байсан нь эдгээр хүн амын хувьд голч нас өөр өөр гарахад нөлөөлжээ (Хүснэгт 1.4). Жишээ нь, ярианы хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын нэг нь 14 хүртэлх насны хүүхдүүд байсан нь бусад хэлбэртэй харьцуулахад хамгийн өндөр хувь байсан бөгөөд үүнээс хамааран ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас хамгийн залуу гарсан байв.


ЗУРАГ 1.8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ГОЛЧ НАС,  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН



Хараа, сонсгол болон хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд голч насны үзүүлэлт нэлээд ойролцоо, 41 жил байхад, хавсарсан болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн голч нас түүнээс 5-6 жилээр өндөр буюу 45.5 жил байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 55.2 хувь нь эрэгтэй, 44.8 хувь нь эмэгтэй байсан ба хүйсийн харьцаа 123 буюу хөгжлийн бэрхшээлтэй 100 эмэгтэйд 123 эрэгтэй ногдож байна.

ЗУРАГ 1.9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР, 2010 ОН



Хүснэгт 1.5-аас харахад 70, түүнээс дээш наснаас бусад бүх насны бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын тоо эмэгтэй хүн амын тооноос олон байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй 55-59 насны эрэгтэйчүүдийн тоо мөн насны эмэгтэйчүүдийн тооноос 2 дахин илүү байлаа. Энэхүү хандлага олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд хадгалагдсан боловч хүйсийн харьцаа 136 болж 23 пунктээр нэмэгдсэн нь олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлд өртөх тохиолдолд эрэгтэйчүүдэд илүүтэй тохиолддогийг дахин баталж байна.

ХҮСНЭГТ 1.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Хөгжлийн бэрхшээлийн төрөл	
		Төрөлхийн	Олдмол
<b>БҮГД</b>	<b>123</b>	<b>103</b>	<b>136</b>
0-4	116	115	121
5-9	122	114	141
10-14	122	118	129
15-19	124	113	143
20-24	140	121	166
25-29	132	111	157
30-34	128	97	136
35-39	121	88	148
40-44	114	84	130
45-49	107	83	115
50-54	134	101	141
55-59	236	135	260
60-64	126	90	133
65-69	108	90	111
70+	71	64	71

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд хүйсийн харьцаа ерөнхийдөө ойролцоо боловч насны бүлэг бүрт харилцан ялгаатай байдал ажиглагджээ. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд 70, түүнээс дээшхи насны бүлгээс бусад насанд хүйсийн харьцаа өндөр буюу эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийн тооноос олон байна. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрүүдээс сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд хүйсийн харьцаа хамгийн ойролцоо буюу 100 эмэгтэйд 108 эрэгтэй ногдож байгаа бол энэ тоо хөгжлийн бэрхшээлийн бусад хэлбэрүүдэд 122-131 байна (Хүснэгт 1.6). Хүйсийн харьцаа 5-9 насны харааны, 35-44 насны сонсголын, 35-39 насны бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд адил байсан бол 55-59 насанд хөгжлийн бэрхшээлийн хэлбэр бүрээр хамгийн их ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, 55-59 насны хавсарсан болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын тоо эмэгтэйчүүдийн тооноос 4 дахин өндөр байлаа.

ХҮСНЭГТ 1.6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ  
БҮЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр					
		Харааны	Ярианы	Сонсголын	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Бусад
<b>БҮГД</b>	<b>123</b>	<b>131</b>	<b>129</b>	<b>122</b>	<b>130</b>	<b>108</b>	<b>122</b>
0-4	116	96	143	163	104	169	119
5-9	122	100	142	127	107	142	148
10-14	122	109	147	124	118	130	116
15-19	124	114	132	134	120	125	132
20-24	140	138	142	157	151	124	138
25-29	132	136	133	133	154	114	128
30-34	128	139	117	112	164	110	118
35-39	121	151	122	100	163	98	100
40-44	114	161	131	100	147	86	99
45-49	107	157	123	101	140	81	85
50-54	134	170	103	137	147	106	126
55-59	236	230	169	186	186	220	416
60-64	126	129	115	168	95	111	223
65-69	108	104	132	165	86	106	151
70+	71	76	72	104	53	76	85

Түүнчлэн цөөн хэдэн насны бүлэгт эмэгтэй хүн амын тоо эрэгтэй хүн амын тооноос олон байсан ба эдгээрээс хамгийн их зөрүүтэй нь хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй 70, түүнээс дээш насныхан байв. Мөн насны хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй 2 эмэгтэйд 1 эрэгтэй ногдсон буюу хүйсийн харьцаа 53 байлаа. Хэдийгээр эрэгтэйчүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлд өртсөн байдал эмэгтэйчүүдээс илүү байгаа боловч 70, түүнээс дээш насанд эрэгтэйчүүдийн тоо цөөн гарсан нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт харьцангуй урт байдагтай холбоотой болно.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор манай улсад халх, казак, буриад, хамниган, сөнөд, цахар зэрэг нийт 29 угсаатан амьдардаг боловч Монгол Улсын харьяат суурин хүн амын хамгийн өндөр буюу 82.4 хувийг халхчууд дангаараа бүрдүүлж байлаа. Үүний дараагаар казахчууд орж байсан ба тэд нийт хүн амын 3.9 хувийг эзэлж байв. Энэхүү хандлага хөгжлийн бэрхшээлтэй хүн амын үндэс, угсаатны бүтцэд мөн хадгалагджээ.

ЗУРАГ 1.10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСААГААР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 107.9 мянга нь Монгол Улсын харьяат, 152 нь гадаадын харьяат иргэд байсан бөгөөд Монгол Улсын харьяат иргэдийн 80.0 хувийг халхчууд бүрдүүлжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын үндэс, угсаатны бүтцийг харвал Монгол Улсын суурин хүн амынхтай ерөнхийдөө ойролцоо байгааг дараах хүснэгтээс харж болно.

### ХҮСНЭГТ 1.7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2010 ОН

Үндэс угсаа	Суурин хүн ам		Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>2 647 545</b>	<b>100.0</b>	<b>108 071</b>	<b>100.0</b>
Монгол улсын харьяат	2 631 117	99.4	107 919	99.9
Халх	2 168 141	82.4	86 437	80.1
Казак	101 526	3.9	4 296	4.0
Дөрвөд	72 403	2.8	3 200	3.0
Буриад	46 087	1.8	2 451	2.3
Баяд	56 573	2.2	2 320	2.1
Дарьганга	27 412	1.0	1 596	1.5
Урианхай	26 654	1.0	1 493	1.4
Захчин	32 845	1.2	1 231	1.1
Дархад	21 558	0.8	1 255	1.2
Хотгойд	15 460	0.6	851	0.8
Өөлд	15 520	0.6	667	0.6
Торгууд	14 176	0.5	529	0.5
Тува	5 169	0.2	270	0.3
Мянгад	6 592	0.3	262	0.2
Барга	2 989	0.1	192	0.2
Үзэмчин	2 577	0.1	166	0.2
Монголын харьяат бусад үндэс, угсаатан	15 435	0.6	703	0.7
Гадаадын харьяат	16 320	0.6	152	0.1
Харьяалалгүй	108	-	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын 4 нь халх, 1 нь халхаас бусад үндэс, угсаатан бөгөөд халхаас бусад угсаатны эзлэх хувь хэмжээ харилцан адилгүй байсан. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 3 хувийг дөрвөд угсаатнууд эзэлж байсан бол мянгад, барга, үзэмчин угсаатнууд тус бүр 0.2 хувийг эзэлсэн байв.

### ХҮСНЭГТ 1.8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Үндэс угсаа	Хот		Хөдөө	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>67 069</b>	<b>100.0</b>	<b>41 002</b>	<b>100.0</b>
Монгол улсын харьяат	66 958	99.8	40 961	99.9
Халх	56 859	84.8	29 578	72.2
Бусад	10 099	15.1	11 383	27.7
Гадаадын харьяат	111	0.2	41	0.1



Нийслэл, аймгийн төв болон тосгонд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 85 орчим хувь нь халхчууд байхад энэ тоо сумын төв болон хөдөөгийн багт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд 12.6 пунктээр доогуур байлаа.


Гэр бүлийн байдлыг гэрлэх, тусгаарлах, цуцлах, бэлэвсрэх, дахин гэрлэх зэрэг ухагдахуунаар ойлгодог бөгөөд гэр бүлийн судалгаанд огт гэр бүл болоогүй, гэр бүлтэй, салсан, бэлэвсэн гэсэн ангиллууд чухал.

**ЗУРАГ 1.11. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДЛААР, 2010 ОН**



2010 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй 98 610 иргэн байгаагийн 33.3 хувь нь огт гэр бүл болоогүй, 45.3 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 7.4 хувь нь хамтран амьдрагчтай, 3.0 хувь нь тусгаарласан, 2.0 хувь нь цуцалсан, 9.0 хувь нь бэлбэсэн болсон гэсэн ангилалд багтаж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн амын гэр бүлийн байдлыг нийт хүн амын гэр бүлийн байдалтай харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

**ЗУРАГ 1.12. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ СУУРИН БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДЛААР, ХУВИАР, 2010 ОН**



\*Тайлбар: Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг гэр бүлтэй, цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг салсан гэсэн ангилалд тус тус оруулав.

Арван тав, түүнээс дээш насны суурин хүн ам болон хөгжлийн бэрхшээлтэй хүн амын аль алиных нь хувьд гэр бүлтэй гэсэн ангилалд багтаж байгаа хүмүүс хамгийн өндөр буюу 60 орчим хувийг эзэлж, дараа нь огт гэр бүл болоогүй хүмүүс орж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын гэр бүлийн байдлыг нийт хүн амтай харьцуулан үзэхэд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй боловч яг адил төвшинд байсангүй. Жишээлбэл, нийт хүн амын дундах гэр бүлтэй хүн амын хувь хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувиас 7 орчим пунктээр өндөр байлаа.

Түүнчлэн Монгол Улсын 15, түүнээс дээш насны 18 хүн тутмын нэг нь (5.5 хувь) бэлбэсэн хүмүүс байсан бол хөгжлийн бэрхшээлтэй 11 хүн тутмын нэг нь (9.0 хувь) ганц бие, өрх толгойлон амьдарч байлаа. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэр бүлийн хувьд эмзэг шинжтэй аж төрөх тохиолдол арай илүү байгааг харуулж байна.


Хөгжлийн бэрхшээлтэй 15, түүнээс дээш насны нийт хүн амын гэр бүлийн байдлыг хүйсээр ангилахад зарим ялгаа ажиглагдсан байна (Хүснэгт 1.9). Тухайлбал, гэр бүлтэй эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс 10 орчим пунктээр өндөр байна. Мөн бэлбэсэн эмэгтэй хүн амын хувь өндөр байгаа нь эрэгтэй хүн амтай харьцуулахад эмэгтэйчүүдийн дундаж наслалт урт, амьдралынхаа сүүлийн хугацаанд ганц биеэр амьдардаг эмэгтэй хүн амын хувийн жин илүү байдагтай холбоотой юм.

### ХҮСНЭГТ 1.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, СОНГОСОН ҮЗҮҮЛЭЛТ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2010 ОН

Сонгосон үзүүлэлт	Бүгд		Огт гэр бүл болоогүй		Гэр бүлтэй		Салсан		Бэлбэсэн	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>98 610</b>	<b>100.0</b>	<b>32 806</b>	<b>33.3</b>	<b>51 984</b>	<b>52.7</b>	<b>4 839</b>	<b>4.9</b>	<b>8 981</b>	<b>9.1</b>
<b>Байршил</b>										
Хот	61 610	100.0	19 690	32.0	32 613	52.9	3 636	5.9	5 671	9.2
Хөдөө	37 000	100.0	13 116	35.4	19 371	52.4	1 203	3.3	3 310	8.9
<b>Хүйс</b>										
Эрэгтэй	54 487	100.0	18 323	33.6	31 096	57.1	2 636	4.8	2 432	4.5
Эмэгтэй	44 123	100.0	14 483	32.8	20 888	47.3	2 203	5.0	6 549	14.9
<b>Хөгжлийн бэрхшээлийн төрөл</b>										
Төрөлхийн	30 492	100.0	18 241	59.8	10 340	33.9	869	2.8	1 042	3.4
Олдмол	68 118	100.0	14 565	21.4	41 644	61.1	3 970	5.8	7 939	11.7

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын 3 нь огт гэрлээгүй бол олдмол хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын 3 нь гэр бүлтэй байсан нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцуулахад олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр болох нь илүүтэй байдгийг харуулж байна.

### ЗУРАГ 1.13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2010 ОН




Хүн амын гэр бүлийн байдалд чухал нөлөөтэй хүчин зүйлийн нэг нь нас байдаг. Огт гэр бүл болоогүй хүн амын хувь нь насны бүлэгтэй урвуу хамааралтай буюу буруу харсан J хэлбэртэй байдаг хандлага хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд давтагдсан байв (Зураг 1.13).

Насны бүлэг нэмэгдэхийн хэрээр огт гэр бүл болоогүй хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувь мэдэгдэхүйц буурчээ. Тодруулбал, 15-19 насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 99.0 хувь нь гэрлээгүй байсан бол 80, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд огт гэр бүл болоогүй хүн ам ердөө 3.9 хувийг эзэлж байв.

Үүний эсрэгээр, насны бүлэг нэмэгдэхийн хэрээр бэлбэсэн хүн амын хувь өссөн байдал ажиглагдаж байна. Жишээ нь 35-39 нас хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүн амд бэлбэсэн хүн амын эзлэх хувь маш бага буюу 1 хүрэхгүй хувь байснаа цаашид нэмэгдэж, харьцангуй ахмад настнууд болох 70, түүнээс дээш насны 5 хүн тутмын 3 нь бэлбэсэн буюу ганц бие амьдарч байлаа. Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүн амын тоо 55-59 нас хүртэл тасралтгүй өсөж, 71.4 хувьд хүрээд цаашид буурсаны шалтгаан нь мөн үүнтэй холбоотойгоор тайлбарлагдана.

Монгол Улсын Үндсэн хуульд хүн амын шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулж өгсөн билээ. Манай улсын 15, түүнээс дээш насны хүн амын 61.4 хувь нь ямар нэгэн шашинтай, 38.6 хувь нь шашингүйчүүд байсан бол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 60.1 хувь нь ямар нэгэн шашинтай, 39.9 хувь шашингүйчүүд байв. Үүнээс харахад, хөгжлийн бэрхшээлтэй хүн амын шашин шүтлэгийн байдал нийт хүн амтай ойролцоо байна.

**ЗУРАГ 1.14. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ШАШИН ШҮТЛЭГЭЭР, 2010 ОН**



Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 50.5 хувь, ямар нэгэн шашинтай хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 83.9 хувийг буддын шашинтан эзэлж байгаа нь бусдаас өндөр хувь байна. Харин христ, ислам, бөө болон бусад шашинг шүтдэг хүн амын хувь нийт хүн амд төдийлөн өндөр хувийг эзлээгүй бөгөөд хариулт нь хоорондоо ялгаа багатай байна.

**ХҮСНЭГТ 1.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ШАШИН ШҮТЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН**

Шашин	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>98 610</b>	<b>100.0</b>	<b>54 487</b>	<b>100.0</b>	<b>44 123</b>	<b>100.0</b>
Шашингүй	39 347	39.9	23 592	43.3	15 755	35.7
Шашинтай	59 263	60.1	30 895	56.7	28 368	64.3
Будда	49 748	50.5	26 314	48.3	23 434	53.1
Христ	3 167	3.2	1 364	2.5	1 803	4.1
Ислам	3 302	3.3	1 674	3.1	1 628	3.7
Бөө	2 681	2.7	1 357	2.5	1 324	3.0
Бусад	365	0.4	186	0.3	179	0.4

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шашин шүтлэгийн байдлыг хүйсээр авч үзэхэд, эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн шашин шүтдэг гэсэн хариулт 7.6 пунктээр өндөр байсан ба энэ хандлага нь нийт хүн амын хувьд мөн ажиглагдсан. Манай улсын 15, түүнээс дээш насны нийт эрэгтэй хүн амын 57.1 хувь, эмэгтэй хүн амын 65.6 хувь нь ямар нэгэн шашинтан байгаа нь эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн онцлогтой холбоотой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн шашин шүтлэгийн байдлыг хариултын давтамжаар үзвэл, нэгд будда, хоёрт, ислам, гуравт христ ба бөөгийн шашин адил хувьтайгаар орсон бол эмэгтэйчүүдийн тухайд будда, христ, ислам, бөө гэсэн дараалалтай харагдаж байна. Эндээс, эрэгтэйчүүд буддагийн дараа исламын шашинг, эмэгтэйчүүдийн буддагийн дараа христийн шашинг илүүд үздэг нь харагдана.

Хөгжлийн бэрхшээл нь төрөлхийн эсвэл олдмол эсэхээс тухайн хүний шашин шүтлэгийн байдал тодорхой хэмжээгээр хамааралтай байна (Хүснэгт 1.11). Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 51.8 хувь нь ямар нэгэн шашинтай ба энэ нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амаас 12.0, хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амаас 8.3 пунктээр тус тус доогуур үзүүлэлт байлаа. Ийнхүү төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын дунд шашин шүтэх явдал харьцангуй доогуур байгаа нь эдгээр хүмүүс насны бүтцийн хувьд залуу байгаатай холбоотой юм. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үндсэн үр дүнд дурьдсанаар 15-19 насныхны шашин шүтдэг байдал 20-49 насныхантай харьцуулахад доогуур байна<sup>1</sup>.


#### ХҮСНЭГТ 1.11. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ШАШИН ШҮТЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН

Шашин	Бүгд		Төрөлхийн		Олдмол	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>98 610</b>	<b>100</b>	<b>30 492</b>	<b>100</b>	<b>68 118</b>	<b>100</b>
Шашингүй	39 347	39.9	14 709	48.2	24 638	36.2
Шашинтай	59 263	60.1	15 783	51.8	43 480	63.8
Будда	49 748	50.5	12 760	41.8	36 988	54.3
Христ	3 167	3.2	1 100	3.6	2 067	3.0
Ислам	3 302	3.3	1 108	3.6	2 194	3.2
Бөө	2 681	2.7	711	2.3	1 970	2.9
Бусад	365	0.4	104	0.3	261	0.4

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр ба шашин шүтлэгийн байдлыг харьцуулан авч үзэхэд, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 51.2 хувь нь ямар нэгэн шашингүйчүүд байсан бөгөөд энэ нь бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй шашингүйчүүдийн хувиас 3.1-15.5 пунктээр өндөр үзүүлэлт байна. Үүний дараагаар ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орж байгаа бөгөөд эдгээр хүмүүсийн 48.1 хувь нь шашингүйчүүд байлаа.

<sup>1</sup> Хүн амын, орон сууцны 2010 оны улсын тооллого. Үндсэн үр дүн, Үндэсний Статистикийн Хороо, Улаанбаатар, 2011 он, 46 дахь тал

**ЗУРАГ 1.15. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ХҮН АМЫН ТОО, ШАШИН ШҮТЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР,  
ХУВИАР, 2010 ОН**



Хөдөлгөөн, хараа, сонсгол, болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын ойролцоогоор 3 нь ямар нэгэн шашин, гол төлөв буддын шашинтай байв. Эндээс харахад, сэтгэн бодох чадваргүй, эсвэл ярьж өөрийн бодол санаагаас илэрхийлэх чадваргүй иргэдийн шашин шүтэх боломж хязгаарлагдмал байна.

### 1.3. БАЙРШИЛ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨЛӨВ

Улсын хэмжээнд тоологдсон хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 62.1 хувь нь хотод, 37.9 хувь нь хөдөөд амьдарч байна.

**ЗУРАГ 1.16. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН**



Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын байршлыг аймаг, нийслэлээр авч үзэхэд тоо хэмжээний хувьд хамгийн цөөн нь буюу 510 хөгжлийн бэрхшээлтэй иргэн Говьсүмбэр аймагт, хамгийн олон нь буюу 37 404 иргэн Улаанбаатар хотод тус тус оршин сууж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо хэмжээний энэхүү ялгаа нь тухайн аймаг, нийслэлийн хүн амын тооноос хамаарч байгаа бөгөөд харьцуулалт хийх үүднээс тэдгээр иргэд тухайн аймаг, нийслэлийнхээ нийт хүн амд хэдэн хувийг эзэлж байгааг харахад, 3.0-6.3 хувь байв. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын 21 аймаг болон нийслэлийн 100 хүн тутмаас 3-6 нь бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, сэтгэхүйн согогтой, үүнээсээ болж нийгмийн амьдралд оролцох боломж нь хязгаарлагдсан иргэд байна (Хүснэгт 1.12).

Өмнөговь, Ховд аймаг, Улаанбаатар хотын нийт хүн амд хөгжлийн бэрхшээлтэй хүн амын эзлэх хувь улсын дунджаас доогуур, Орхон, Говьсүмбэр аймгийнх улсын дундажтай


адил, бусад 17 аймагт улсын дундаж үзүүлэлтээс 0.1-2.4 пунктээр өндөр байна. Хэнтий болон Сүхбаатар аймгийн нийт хүн амын 6-аас илүү хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлж байсан нь эдгээр аймгуудад хөгжлийн бэрхшээлийн тохиолдол бусад аймгууд болон нийслэлээс өндөр байгааг харуулж байна.

#### ХҮСНЭГТ 1.12. СУУРИН ХҮН АМ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Суурин хүн амын тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>2 754 685</b>	<b>108 071</b>	<b>3.9</b>
Архангай	84 584	3 720	4.4
Баян-Өлгий	88 056	3 856	4.4
Баянхонгор	76 085	3 696	4.9
Булган	53 655	2 318	4.3
Говь-Алтай	53 590	2 528	4.7
Дорноговь	58 612	2 560	4.4
Дорнод	69 552	4 082	5.9
Дундговь	38 821	1 881	4.8
Завхан	65 481	2 939	4.5
Өвөрхангай	101 314	4 604	4.5
Өмнөговь	61 314	2 183	3.6
Сүхбаатар	51 334	3 057	6.0
Сэлэнгэ	97 584	4 711	4.8
Төв	85 166	3 825	4.5
Увс	73 328	3 358	4.6
Ховд	76 870	2 896	3.8
Хөвсгөл	114 926	6 553	5.7
Хэнтий	65 811	4 136	6.3
Дархан-Уул	94 625	3 738	4.0
Улаанбаатар	1 240 037	37 404	3.0
Орхон	90 700	3 516	3.9
Говьсүмбэр	13 240	510	3.9


Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын шилжих хөдөлгөөнийг 15, түүнээс дээш насны нийт 98 610 хүний хувьд тооцож үзэхэд 44 828 нь төрсөнөөс хойш ямар нэгэн байдлаар шилжих хөдөлгөөнд оролцсон, 53 782 нь шилжих хөдөлгөөнд оролцоогүй иргэд байв. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй 15, түүнээс дээш насны хүн амын 45.5 хувь нь тухайн аймаг/нийслэлдээ төрснөөсөө хойш оршин сууж байгаа буюу шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүмүүс ажээ.

**ЗУРАГ 1.17. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН  
ТОО, ТӨРСӨНӨӨС ХОЙШ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН ЭСЭХЭЭР, 2010 ОН**



Хөгжлийн бэрхшээлтэй 15, түүнээс дээш насны нийт хүн амын 54.5 хувь нь тухайн аймаг/нийслэлдээ өөр газар амьдарч байгаад буцаж ирсэн, эсвэл өөр газраас шилжин ирсэн буюу шилжих хөдөлгөөнд оролцогчид байсан ба төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд шилжих хөдөлгөөнд оролцсон байдал харьцангуй бага байв. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 10 хүн тутмын 3 нь төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцогчид байсан бол энэ тоо олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд 20 орчим пунктээр өндөр байна. Эндээс, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс харьцангуй бага шилжилт хийдэг байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

**ЗУРАГ 1.18. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН  
ТОО, ТӨРСӨНӨӨС ХОЙШ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН ЭСЭХ,  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН**



Төрсөнөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй 4 хүн тутмын нэг нь өөр газарт амьдарч байгаад тухайн аймаг/нийслэлдээ буцаж ирсэн бол 3 нь өөр газраас шилжин ирж, тухайн орон нутагт суурьшсан байв.





# ХОЁРЛУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖ БАЙДАЛ





## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖ БАЙДАЛ

Энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын үйлчилгээний хүртээмж, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, ажил эрхлэлт ба эдийн засгийн идэвх, гар утас, интернэтийн хэрэглээ зэрэг нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, хүйс, байршил зэрэг шинж байдлаар харьцуулан танилцуулж байна.

### 2.1. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Хүн амын боловсролын төвшний үзүүлэлт нь төр, засгаас хүнийг хөгжүүлэхэд оруулсан хөрөнгө оруулалтын өнгөрсөн, одоо, ирээдүйн үр дүнг илэрхийлдэг нийгэм, эдийн засгийн цогц үзүүлэлт билээ. 2000, 2010 оны тооллогын үр дүнг харьцуулан үзэхэд манай улсын хүн амын боловсролын ерөнхий төвшин дээшилсэн хандлага ажиглагддаг. Тухайлбал, 2000 онд 15, түүнээс дээш хүн амын 2.2<sup>1</sup> хувь бичиг үсэгт тайлагдаагүй байсан бол 2010 онд 1.7 хувь болж буурсан байна.

Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 10, түүнээс дээш насны нийт 103.0 мянган иргэн байгаагийн 80.4 мянга нь албан боловсрол эзэмшсэн, 22.6 мянга нь боловсрол эзэмшээгүй хүн байв.

ЗУРАГ 2.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО,  
БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР, 2010 ОН




Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй 10, түүнээс дээш насны нийт хүн амд боловсролтой хүн ам 78.0, боловсролгүй хүн ам 22.0 хувийг эзэлж байгаа ба үүнийг 10, түүнээс дээш насны Монгол Улсын нийт хүн амын үзүүлэлттэй харьцуулан үзвэл дараах байдалтай байна (Зураг 2.2).

Монгол Улсын 10, түүнээс дээш насны хүн амын 92.5 хувь нь ямар нэг төвшний боловсрол эзэмшсэн байхад, хөгжлийн бэрхшээлтэй 10, түүнээс дээш насны боловсролтой хүн амын хувь түүнээс 14.5 пунктээр доогуур байв.

Хөгжлийн бэрхшээлтэй болон нийт хүн амын аль алиных нь хувьд бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүн амын хувь хамгийн өндөр буюу 30 орчим хувь бөгөөд үүний дараагаар суурь, бага боловсрол орж байна.

<sup>1</sup> Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого. *Боловсрол, бичиг үсгийн мэдлэг* сэдэвчилсэн судалгаа, Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, 2002 он, 3 дахь тал

**ЗУРАГ 2.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ СУУРИН БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2010 ОН**



Дээд боловсролтой эсвэл боловсрол эзэмшээгүй хүн амын хувьд хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс хамааран мэдэгдэхүйц ялгаа ажиглагджээ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 7.7 хувь нь дээд боловсролтой байхад нийт хүн амын дундах дээд боловсролтой хүн амын эзлэх хувь түүнээс 2.4 дахин өндөр байв. Эсрэгээр, хөгжлийн бэрхшээлтэй ямар нэгэн боловсрол эзэмшээгүй хүн амын хувь нийт хүн амаас 3 дахин өндөр байна.

Улсын хэмжээнд 10, түүнээс дээш насны нийт хүн амын 1.7 хувь нь бичиг үсэгт тайлагдаагүй буюу энгийн зүйлийг уншиж, бичиж, ойлгох чадваргүй иргэд байхад, энэ тоо хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд 14.6 хувь байв. Өөрөөр хэлбэл, манай улсын 10, түүнээс дээш насны 100 хүн тутмаас 1-2 нь бичиг үсэгт тайлагдаагүй бол хөгжлийн бэрхшээлтэй 100 хүн тутмаас 14-15 нь бичиг үсэгт тайлагдаагүй ажээ.


**ХҮСНЭГТ 2.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН**

Боловсролын түвшин	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>103 046</b>	<b>100.0</b>	<b>56 925</b>	<b>100.0</b>	<b>46 121</b>	<b>100.0</b>
<b>Боловсролтой</b>	<b>80 388</b>	<b>78.0</b>	<b>44 946</b>	<b>79.0</b>	<b>35 442</b>	<b>76.8</b>
Дээд	7 935	7.7	4 312	7.6	3 623	7.9
Тусгай мэргэжлийн дунд	6 362	6.2	3 057	5.4	3 305	7.2
Техник мэргэжлийн	3 646	3.5	2 149	3.8	1 497	3.2
Бүрэн дунд	25 821	25.1	14 156	24.9	11 665	25.3
Суурь	19 162	18.6	11 729	20.6	7 433	16.1
Бага	17 462	16.9	9 543	16.7	7 919	17.1
<b>Боловсролгүй</b>	<b>22 658</b>	<b>22.0</b>	<b>11 979</b>	<b>21.0</b>	<b>10 679</b>	<b>23.2</b>
Бичиг үсэг мэддэг	7 638	7.4	4 158	7.3	3 480	7.6
Бичиг үсэг мэддэггүй	15 020	14.6	7 821	13.7	7 199	15.6

Боловсролын төвшинд хүйсийн ялгаа төдийлөн өндөр биш байсан хандлага хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тухайд ч давтагджээ (Хүснэгт 2.1). Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хувьд бүрэн дунд боловсролтой иргэн хамгийн өндөр буюу 25 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд үүний дараагаар эрэгтэй хүн амд суурь, эмэгтэй хүн амд бага боловсрол эзэмшсэн иргэд орж байлаа.

Хүн амын боловсролын төвшин, түүн дотроо хөгжлийн бэрхшээлтэй хүн амын боловсролын төвшинд байршлын үзүүлэлт ихээхэн чухал хүчин зүйл байна.

**ЗУРАГ 2.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН**



Хот суурин газарт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй 10 хүн тутмын 3 нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байгаа нь хамгийн өндөрт тооцогдох үзүүлэлт байсан бол хөдөөгийн иргэдийн 32.1 хувь нь боловсрол эзэмшээгүй байсан нь боловсролын төвшний бусад ангилалтай харьцуулахад өндөр хувийг эзэлж байв. Энэ нь хот суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнд боловсрол эзэмших боломж тэр болгон нээлттэй бус байгааг илэрхийлж байна.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 2 хүн тутмын нэг нь боловсрол эзэмшиж, нөгөө нь боловсролгүй орхигдож байгааг Хүснэгт 2.2-оос харж болно. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, боловсрол эзэмшээгүй хүн амын дотор бичиг үсэггүй, боловсролтой хүн амын дотор анхан шатны боловсрол эзэмшсэн хүн амын хувь өндөр байна.

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 87.8 хувь нь боловсрол эзэмшсэн бөгөөд боловсрол эзэмшээгүй ч бичиг үсэг үл мэддэг байдал харьцангуй доогуур байна. Энэ нь удамшил, төрөлттэй холбоотой шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй төрсөн хүн амын хувьд боловсрол эзэмших нөхцөл бололцоо хангалтгүй байдгийг харуулна.


Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийн хувьд ярианы болон сэтгэцийн бэрхшээлтэй 2 хүн тутмын нэг нь боловсролгүй хүмүүс байхад, бусад хэлбэрийн бэрхшээлтэй иргэдийн 11.7-19.6 хувь нь боловсрол эзэмшээгүй байлаа. Үүнээс харахад яриа болон сэтгэцийн бэрхшээл нь хараа, сонсгол, хөдөлгөөний эрхтний бэрхшээлтэй харьцуулахад тухайн хүмүүсийн сурч боловсрох боломжийг илүүтэй хязгаарладаг байна.

ХҮСНЭГТ 2.2. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр	Бүгд		Боловсролтой				Боловсролгүй			
			Бүрэн дундаас дээш		Бүрэн дунд ба түүнээс доош		Бичиг үсэг мэддэг		Бичиг үсэг мэддэггүй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>105 586</b>	<b>100.0</b>	<b>17 943</b>	<b>17.0</b>	<b>62 477</b>	<b>59.2</b>	<b>9 131</b>	<b>8.6</b>	<b>16 035</b>	<b>15.2</b>
<b>Хөгжлийн бэрхшээлийн төрөл</b>										
Төрөлхийн	34 955	100.0	2 439	7.0	15 981	45.7	4 616	13.2	11 919	34.1
Олдмол	70 631	100.0	15 504	22.0	46 496	65.8	4 515	6.4	4 116	5.8
<b>Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр</b>										
Харааны	16 161	100.0	3 087	19.1	10 301	63.7	1 682	10.4	1 091	6.8
Ярианы	5 734	100.0	372	6.5	2 412	42.1	821	14.3	2 129	37.1
Сонсголын	12 524	100.0	1 993	15.9	8 080	64.5	1 131	9.1	1 320	10.5
Хөдөлгөөний	30 345	100.0	6 027	19.9	19 681	64.9	2 439	8.0	2 198	7.2
Сэтгэцийн	20 598	100.0	1 645	8.0	8 973	43.6	1 880	9.1	8 100	39.3
Бусад	20 224	100.0	4 819	23.8	13 030	64.5	1 178	5.8	1 197	5.9

Улсын хэмжээнд 2010 оны 11 дүгээр сарын байдлаар сургуулиас өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах насны, хөгжлийн бэрхшээлтэй нийт 1 986 хүүхэд байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 1.8 хувийг бүрдүүлж байна. Эдгээр хүүхдүүдийн хувьд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах байдал ямар байгааг судлахад 5 хүүхэд тутмын ойролцоогоор 2 нь (38.7 хувь) сургуулийн өмнөх боловсролын байгууллага болох цэцэрлэгийн үйлчилгээнд хамрагддаг бөгөөд энэ тоо улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад 21.4 пунктээр доогуур төвшин юм. Ийнхүү хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдалт доогуур байгаа нь нэг талаас эдгээр хүүхдэд зориулсан цэцэрлэгийн хүртээмж төдийлөн хангалттай бус байдагтай, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд тусгайлсан асаргаа шаардлагатай учраас эцэг, эхчүүд тэр болгон цэцэрлэгт хүүхдээ хүмүүжүүлэх сонирхолгүй байдагтай холбоотой юм.

ЗУРАГ 2.4. 2-5 НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ТОО, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



Байршлын хувьд хоттой харьцуулахад хөдөөд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа нь нас болгонд ажиглагджээ. Улмаар хот, хөдөө болон нийт дүнгээр авч үзсэн үзүүлэлтийн аль алиных нь хувьд насны бүлэг дээшлэхийн хэрээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах нь өссөн байв. Өөрөөр хэлбэл 2 настай хүүхэдтэй харьцуулахад 3 настай хүүхдийн, 3 настай хүүхэдтэй харьцуулахад 4 настай хүүхдийн, 4 настай хүүхэдтэй харьцуулахад 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдалт өндөр байгаа нь улсын төвшний үзүүлэлттэй адил дүр зураг байв.

Боловсролын тухай хуульд зааснаар хүүхэд бүр 16 нас хүртлээ заавал суралцах ёстой бөгөөд төрийн өмчийн сургууль ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно. Гэвч ерөнхий боловсролын сургуульд хамрагдах нь байршил, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр зэргээс хамааран харилцан адилгүй хандлагатай байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээс харахад, манай улсад ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насны буюу 6-19 насны нийт 13.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагийн 55.6 хувь нь зохих түвшний сургуульдаа хамрагдаж, 44.4 хувь нь ерөнхий боловсролын сургуулийн гадна үлдэж байна.

### ХҮСНЭГТ 2.3. 6-29 НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ, ХҮН АМЫН ТОО, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>30 132</b>	<b>30.7</b>	<b>17 031</b>	<b>28.0</b>	<b>13 101</b>	<b>34.3</b>
6-9	2 540	67.2	1 399	66.3	1 141	68.2
10-14	4 436	66.9	2 438	63.5	1 998	71.1
15-17	3 626	50.6	1 958	46.7	1 668	55.2
18-19	2 764	33.5	1 581	29.7	1 183	38.6
6-19	13 366	55.6	7 376	52.3	5 990	59.7
20-24	7 933	16.5	4 625	13.8	3 308	20.2
25-29	8 833	5.8	5 030	5.3	3 803	6.8
20-29	16 766	10.7	9 655	9.4	7 111	12.9

\*Тайлбар: Сургуульд хамрагдах насны дээд хязгаар байхгүй.

6-29 насны хөгжлийн бэрхшээлтэй 30.1 мянган хүний 9.3 мянга нь буюу 30.7 хувь нь зохих төвшний сургуульд суралцдаг, албан боловсролын дүйцсэн хөтөлбөрт хамрагддаг ажээ. Энэ тоог Монгол Улсын 6-29 насны нийт хүн амын 58.1<sup>1</sup> хувь нь сургуульд суралцаж байна гэсэн тоо баримттай харьцуулбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхээ эдлэх боломж хангалтгүй байгааг харуулна.


Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд суралцах хүсэл, эрмэлзэл байвч манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй чөлөөтэй зорчих гудамж талбай, зам, нийтийн тээвэр, барилга байгууламж, цаашлаад сургалтын байгууллагад тэдэнд зориулсан шат, ариун цэврийн өрөө, сандал ширээ гэх мэт наад захын хэрэгцээт зүйлс байдаггүй. Мөн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан сургалтын тусгай хөтөлбөр, материал, гарын авлага хүрэлцээгүй байдаг нь "Өвөрхангай аймгийн тусгай сургалттай ангийн 24 хүүхэд дундаа 1975 онд хэвлэгдсэн дохионы хэлний 2 цагаан толгойн номтой" гэх кейс мэдээллээр батлагдаж байна<sup>2</sup>.

<sup>1</sup> Хүн амын, орон сууцны 2010 оны улсын тооллого. Үндсэн үр дүн, Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар, 2011 он, 53 дахь тал

<sup>2</sup> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох болон хөдөлмөрлөх эрх судалгааны тайлан, USAID, MercyCorps, Улаанбаатар, 2010 он, 25 дахь тал

Хүйсийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй охидтой харьцуулахад хөвгүүдийн сургуульд хамрагдах нь доогуур байна. Ялангуяа, 10-14, 15-17, 18-19 насанд энэ ялгаа илүү тод ажиглагдсан бөгөөд мөн насны сургуульд суралцаж байгаа эсвэл албан боловсролын дүйцсэн хөтөлбөрт хамрагдаж байгаа охидын хувь хөвгүүдээс 8 орчим пунктээр өндөр байлаа. Өөрөөр хэлбэл бүх шатны сургуульд хамрагдалт эмэгтэй хүн амын хувьд илүү байдаг хандлага хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тухайд давтагдсан байлаа.

**ЗУРАГ 2.5. 6-29 НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН**



Хот, суурин газар буюу нийслэл Улаанбаатар хот, аймгийн төвд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалт сумын төв болон хөдөө амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад өндөр байна. 6-19 буюу ерөнхий боловсролын сургууль, 20-29 буюу их, дээд сургуульд суралцах насны аль алинд нь хөдөөгийн хүн амын сургуульд хамрагдах байдал хотын хүн амаас 10 орчим пунктээр доогуур байв.

## 2.2. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор хүн амын эдийн засгийн идэвхийг 15, түүнээс дээш насныхны одоогийн ажил эрхлэлтийн байдал, ажиллаж буй байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн статус, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан гэсэн үндсэн 4 үзүүлэлтээр авч үзсэн болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын ажил эрхлэлт, эдийн засгийн идэвхийг эдгээр үзүүлэлтээр авч үзэв.

**ЗУРАГ 2.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЭЭР, 2010 ОН**





Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 15, түүнээс дээш насны 98.6 мянган хүн байгаагийн 19.7 мянга нь тооллогоос өмнөх 7 хоногт орлогын эх үүсвэртэй болох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд нэгээс дээш цагаар оролцсон буюу ажил эрхэлдэг иргэн, 78.9 мянга нь ажил эрхэлдэггүй иргэн байсан. Ажил эрхэлдэггүй хүн амын 2 915 нь ажиллах хүчинд багтахуйц, өөрөөр хэлбэл тооллогын үед ажил идэвхтэй эрж хайж байгаа ажилгүйчүүд байв.

Тооллого явагдахаас өмнөх 7 хоногт ажил эрхэлж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүн ам нь 15, түүнээс дээш насны хүн амын 19.9 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үүнийг Монгол Улсын ажил эрхэлдэг суурин хүн амтай харьцуулбал 2.4 дахин доогуур үзүүлэлт байв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн одоогийн ажил эрхлэлтийг хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрээр харьцуулан үзвэл хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ялгаа багатай, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийн хувьд мэдэгдэхүйц ялгаатай байдал ажиглагдсан. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 21.6 хувь, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 19.2 хувь нь тооллогоос өмнөх 7 хоногт дор хаяж нэг цаг эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцсон байна.

#### ХҮСНЭГТ 2.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЭСЭХ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр	Бүгд		Ажил эрхэлдэг		Ажил эрхэлдэггүй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>98 610</b>	<b>100.0</b>	<b>19 657</b>	<b>19.9</b>	<b>78 953</b>	<b>80.1</b>
<b>Хөгжлийн бэрхшээлийн төрөл</b>						
Төрөлхийн	30 492	100.0	6 575	21.6	23 917	78.4
Олдмол	68 118	100.0	13 082	19.2	55 036	80.8
<b>Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр</b>						
Харааны	14 759	100.0	4 313	29.2	10 446	70.8
Ярианы	4 774	100.0	1 031	21.6	3 743	78.4
Сонсголын	11 863	100.0	3 337	28.1	8 526	71.9
Хөдөлгөөний	28 562	100.0	5 401	18.9	23 161	81.1
Сэтгэцийн	19 297	100.0	2 112	10.9	17 185	89.1
Бусад	19 355	100.0	3 463	17.9	15 892	82.1

Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзэхэд, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхэлсэн хувь хамгийн бага буюу 10.9 хувь байна. Хараа болон сонсголын эрхтний бэрхшээлтэй иргэд яриа, хөдөлгөөн, сэтгэц болон бусад хэлбэрийн эмгэгтэй хүмүүсээс илүүтэй ажил хийж байгаа байдал ажиглагдлаа.

Ажил эрхлэх нь тухайн хүний эзэмшсэн боловсролын төвшингээс шууд хамааралтай байна (Зураг 2.7).


Ямар нэгэн боловсрол эзэмшээгүй хүн амын 14.9 хувь нь ажил эрхэлдэг байхад боловсролын төвшин нэмэгдэхийн хэрээр ажил эрхлэлт өсч, дээд боловсролтой хүн амын хувьд 30.9 хувь нь ажил эрхэлж байв.

ЗУРАГ 2.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2010 ОН



Ийнхүү ажил эрхлэлт нь боловсролын төвшингөөс шууд хамаарч байгаа нь нэг талаас ажлын байранд тавигддаг гол шалгууруудын нэг нь боловсрол, мэргэжлийн ур чадвар болохыг харуулж байна. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хэдий ч боловсрол эзэмшиж байгаа хүмүүс бол цаашид ажиллаж, хөдөлмөрлөх чадвар, сонирхолтой иргэд учраас ажил эрхлэлт нь харьцангуй өндөр гарсан.

ЗУРАГ 2.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Ажил эрхлэлтийн төвшин нь нас болон хүйсээс хэрхэн хамаарч байгааг тодруулахад 45-49 нас хүртэл өсч, мөн насанд хамгийн өндөр төвшинд хүрээд эргэж буурсан хандлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй ажил эрхэлж байгаа эрэгтэй хүн амын 14.4 хувь, эмэгтэй хүн амын 18.1 хувийг 45-49 насныхан эзэлж байгаа нь бусад насны бүлгийн хүн амын эзлэх хувиас 0.6-17.3 пунктээр өндөр төвшин юм.

15-24, 55-59 насанд ажил эрхэлж байгаа эрэгтэй хүн амын хувь эмэгтэй хүн амын хувиас өндөр, 35-49 насанд эсрэгээр буюу ажил эрхэлж буй эмэгтэй хүн амын хувь өндөр байна.

### Хүснэгт 2.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН СТАТУС, ХУВИАР, 2010 ОН


Ажил эрхлэлтийн статус	Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам		Суурин хүн ам	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>19 657</b>	<b>100.0</b>	<b>911 664</b>	<b>100.0</b>
Цалин хөлстэй ажиллагч	7 016	35.7	512 628	56.2
Ажил олгогч	321	1.6	23 005	2.5
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	8 193	41.7	252 715	27.7
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	66	0.3	1 854	0.2
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	3 949	20.1	117 764	12.9
Бусад	112	0.6	3 698	0.5

Тооллогоор “ажил эрхэлдэг” хэмээн бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил эрхлэлтийн статусаар нь судлахад, 41.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 35.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 20.1 хувь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, 1.6 хувь нь ажил олгогч, 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байв.

Харин нийт хүн амын хувьд цалин хөлстэй ажиллагч хамгийн өндөр буюу 56.2 хувийг эзэлж байхад, хувиараа хөдөлмөр эрхлэгч түүнээс 2 дахин бага хувьтай байна. Үүнээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төсвийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад буюу албан хэвшилд гэрээ байгуулан ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал, эсрэгээр албан бус хэвшилд ажиллах эсвэл цалин хөлсгүйгээр өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох байдал харьцангуй илүү байдаг ажээ.

Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 76 038 нь буюу 77.1 хувь нь сургуульд суралцаж байгаа, тэтгэвэрт, ажил эрхлэх сонирхолгүй зэрэг шалтгаанаар тооллогын үед ажил эрхлээгүй, өөрөөр хэлбэл эдийн засгийн идэвхгүй хүн ам байна.

### ЗУРАГ 2.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН, ХУВИАР, 2010 ОН



Эдгээр хүмүүсийн ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг авч үзвэл хөдөлмөр эрхлэх чадваргүй болон тэтгэвэрт байдаг гэсэн шалтгаан зонхилох хувийг бүрдүүлжээ. Тэтгэвэрт байдаг гэсэн шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын нэг нь ажил эрхлэхгүй байгаа явдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд насны бүтцийн хувьд харьцангуй хөгшин, хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амд тэтгэврийн буюу 60, түүнээс дээш насныхан 12 орчим хувийг эзэлж байгаатай холбоотой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын ажил эрхлээгүй шалтгааныг нийт хүн амтай харьцуулан үзвэл нэлээд ялгаатай байсан. Тодруулбал, манай улсын 15, түүнээс дээш насны хүн амын хувьд сургуульд сурдаг гэсэн шалтгаан хамгийн өндөр (36.2 хувь), хөдөлмөрийн чадваргүй гэсэн шалтгаан харьцангуй бага (6.7 хувь) хувийг эзэлсэн билээ.

**ХҮСНЭГТ 2.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН**

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр	Хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан						Бүгд		
	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй	Ажиллах сонирхолгүй	Бусад	Хувь	Хүний тоо
<b>БҮГД</b>	<b>4.8</b>	<b>18.7</b>	<b>63.9</b>	<b>3.0</b>	<b>4.5</b>	<b>0.2</b>	<b>4.9</b>	<b>100.0</b>	<b>76 038</b>
<b>Хөгжлийн бэрхшээлийн төрөл</b>									
Төрөлхийн	7.6	6.3	72.7	3.9	4.6	0.2	4.7	100.0	22 885
Олдмол	3.6	24.0	60.2	2.6	4.5	0.1	5.0	100.0	53 153
<b>Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр</b>									
Харааны	10.3	33.4	39.8	4.4	7.0	0.1	5.0	100.0	9 771
Ярианы	6.5	13.0	65.9	4.0	5.3	0.2	5.1	100.0	3 582
Сонсголын	7.4	26.0	45.9	5.9	9.1	0.2	5.5	100.0	7 947
Хөдөлгөөний	4.8	24.5	61.2	2.2	3.8	0.1	3.4	100.0	22 423
Сэтгэцийн	1.9	5.5	84.1	1.8	2.3	0.1	4.3	100.0	16 896
Бусад	2.9	13.0	69.9	2.9	4.1	0.1	7.1	100.0	15 419

Ажил эрхлээгүй шалтгаан нь байршлаар төдийлөн ялгаагүй боловч хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрээр нэлээд ялгаатай байв. Төрөлхийн ба олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын аль алиных нь хувьд хөдөлмөр эрхлэх чадваргүй гэсэн хариулт 60-70 хувь байгаа нь хамгийн өндөр төвшин байлаа.

Харах, сонсох эрхтний бэрхшээлтэй хүмүүс бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцуулахад хөдөлмөр эрхлэх чадваргүй гэсэн хариултыг харьцангуй бага өгсөн нь эдгээр хүмүүст бие махбодийн хувьд хөдөлмөр эрхлэх чадвар илүү байдгийг харуулж байна. Улмаар ажил эрхэлж буй хүн амын хувь харааны болон сонсголын эрхтний бэрхшээлтэй иргэдийн дунд харьцангуй өндөр байсан нь дээрх мэдээлэлтэй уялдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас хөдөлмөр эрхлэх чадваргүй, улмаар тэдний хөдөлмөрлөх орчин, нийгэм сэтгэл зүйн уур амьсгал бүрдээгүй байгаа нь тэднийг орлого, аж байдлын хувьд ядуу гэсэн ангилалд багтахад нөлөөлж байхыг үгүйсгэх аргагүй юм<sup>1</sup>.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын эдийн засгийн идэвхийг харуулах зарим үзүүлэлтийг шинж байдлын гол үзүүлэлтээр харьцуулан Хүснэгт 2.7-д үзүүлэв.

Тооллогын үед “ажил хайж байгаа” гэсэн шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг эдийн засгийн идэвхтэй хүн амын нэг хэсэг болох ажилгүйчүүд гэсэн ангилалд оруулсан. Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд ажил хайж байгаа хүмүүс буюу ажилгүйчүүдийн эзлэх хувь нь хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нэлээд ялгаатай, байршил болон хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ялгаа багатай байв. Тухайлбал, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 1.5 хувийг ажил хайж байгаа иргэд эзэлсэн бол хараа, сонсголын хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 5 орчим хувийг ажил хайж байгаа иргэд эзэлжээ.

<sup>1</sup> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох болон хөдөлмөрлөх эрх судалгааны тайлан, USAID, MercyCorps, Улаанбаатар, 2010 он, 29 дэх тал

## ХҮСНЭГТ 2.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, СОНГОСОН ҮЗҮҮЛЭЛТ, ХУВИАР, 2010 ОН


Сонгосон үзүүлэлт	15, түүнээс дээш насны нийт хүн ам	Ажилгүйчүүд		Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)		Ажилгүйдлийн түвшин (хувь)
		Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	
<b>БҮГД</b>	<b>98 610</b>	<b>2 915</b>	<b>3.0</b>	<b>22 572</b>	<b>22.9</b>	<b>12.9</b>
<b>Хөгжлийн бэрхшээлийн төрөл</b>						
Төрөлхийн	30 492	1 032	3.4	7 607	24.9	13.6
Олдмол	68 118	1 883	2.8	14 965	22.0	12.6
<b>Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр</b>						
Харааны	14 759	675	4.6	4 988	33.8	13.5
Ярианы	4 774	161	3.4	1 192	25.0	13.5
Сонсголын	11 863	579	4.9	3 916	33.0	14.8
Хөдөлгөөний	28 562	738	2.6	6 139	21.5	12.0
Сэтгэцийн	19 297	289	1.5	2 401	12.4	12.0
Бусад	19 355	473	2.4	3 936	20.3	12.0
<b>Байршил</b>						
Хот	61 610	1 809	2.9	10 227	16.6	17.7
Хөдөө	37 000	1 106	3.0	12 345	33.4	9.0

Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй 98 610 хүний 22.9 хувь нь болох 22 572 хүн эдийн засгийн идэвхтэй байв. Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүч нь хөдөлмөрийн насны хүн амд 12.4-33.8 хувийг эзэлсэн бөгөөд байршлаар авч үзвэл хамгийн их ялгаа ажиглагджээ. Тухайлбал, хотын хүн амын 16.6 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн амд багтаж байсан бол хөдөөгийн хүн амын 33.4 хувь нь мөн ангилалд багтжээ. Хот, хөдөөгийн аль алинд ажилгүйчүүдийн хувь бараг адил боловч эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь ийнхүү ялгаатай гарсан нь хөдөөгийн хүн амын дунд ажил эрхэлж байгаа, тодруулбал мал аж ахуй эрхэлдэг хүн амын хувь хэмжээ өндөр байгаагаар тайлбарлагдана. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын ажилгүйдлийн төвшин 12.9 хувь байсан ба энэ тоо хөдөөд хамгийн бага буюу 9.0 хувь, бусад шинж байдал бүхий хүн амын хувьд 17.7 хүртэлх төвшинд байна.

### 2.3. ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Мэдээлэл, харилцаа холбооны технологи хөгжиж, хэрэглээ нь өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа энэ үед гар утас болон интернэтийн хэрэглээний үзүүлэлтийг Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулгад оруулсан болно. Монгол Улсын 6, түүнээс дээш насны 105.6 мянган хүний 74.0 хувь нь гар утас, 30.6 хувь нь интернэт хэрэглэдэг бол уг үзүүлэлт хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тухайд 55.1 ба 10.3 хувьтай байна.

### ЗУРАГ 2.10. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ГАР УТАС, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭГЭЭР, 2010 ОН



Гар утас, интернэтийн хэрэглээг байршлаар авч үзвэл сумын төв болон хөдөөгийн багтай харьцуулахад нийслэл, аймгийн төв, тосгонд өндөр байна.

**ЗУРАГ 2.11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ 6, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГАР УТАС, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН**



Хот суурин газарт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй 6, түүнээс дээш насны хүн амын 64.3 хувь нь гар утас хэрэглэдэг бол хөдөө орон нутагт энэ үзүүлэлт 24.2 пунктээр доогуур байв. Хөдөөгийн оршин суугч 100 хүн тутмын 2-3 нь интернэт хэрэглэдэг бол хотод оршин суугч, интернэт хэрэглэгчдийн тоо түүнээс 6-7 дахин өндөр байв. Энэ нь аймгийн төв, нийслэлтэй харьцуулахад сумын төв болон хөдөөд дэд бүтцийн үйлчилгээ хангалтгүй байдагтай холбоотой. Тухайлбал, цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, үүрэн утасны сүлжээгүй, интернэтэд холбогдоогүй сумууд цөөн боловч байгаа билээ.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд гар утас болон интернэтийн хэрэглээний төвшин өндөр байна.

**ХҮСНЭГТ 2.8. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН ТОО, ГАР УТАС, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН**

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр	6, түүнээс дээш насны хүн амын тоо	Гар утас хэрэглэдэг		Интернэт хэрэглэдэг	
		Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>105 586</b>	<b>58 218</b>	<b>55.1</b>	<b>10 829</b>	<b>10.3</b>
<b>Хөгжлийн бэрхшээлийн төрөл</b>					
Төрөлхийн	34 955	14 230	40.7	2 991	8.6
Олдмол	70 631	43 988	62.3	7 838	11.1
<b>Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр</b>					
Харааны	16 161	10 092	62.4	2 287	14.2
Ярианы	5 734	1 842	32.1	394	6.9
Сонсголын	12 524	7 054	56.3	1 414	11.3
Хөдөлгөөний	30 345	18 908	62.3	3 600	11.9
Сэтгэцийн	20 598	6 393	31.0	703	3.4
Бусад	20 224	13 929	68.9	2 431	12.0

Тухайлбал, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын 2 нь гар утас хэрэглэдэг бол олдмол хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын 3 нь гар утас ашигладаг байв. Улмаар ярьж чаддаггүй, эсвэл сэтгэцийн эрхтний бэрхшээлтэй иргэд гар утас болон интернэт хэрэглэх чадамжгүй учир мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ доогуур төвшинд байлаа.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ШИНЖ БАЙДАЛ,  
АХУЙН НӨХЦӨЛ







## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ШИНЖ БАЙДАЛ, АХУЙН НӨХЦӨЛ

Энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн бүтэц, амьдарч буй сууцны зориулалт ба эзэмшил, цахилгаан, халаалт, бие засах, хатуу хог хаягдал зайлуулах байгууламж зэрэг ахуйн нөхцлийн гол үзүүлэлтийг байршил болон байшингийн төрлөөр харьцуулан танилцуулж байна.

### 3.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, БҮТЭЦ


Хүн ам, орон сууцны 2010 улсын улсын тооллогоор манай улсад нийт 713 780 өрх бүртгэгдсэний 86.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнгүй, 93 365 өрх хөгжлийн бэрхшээлтэй нэг, түүнээс дээш тооны хүнтэй байна. Энэ нь Монгол Улсын 100 өрх тутмын 13-д нь хөгжлийн бэрхшээлтэй дор хаяж нэг хүн байна гэсэн үг бөгөөд цар хүрээний хувьд хөгжлийн бэрхшээл нь нийт өрхийн дунд багагүй тархалттай болох нь харагдаж байна.

ЗУРАГ 3.1. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ӨРХИЙН ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ХҮНИЙ ТООГООР, 2010 ОН



Байршлаар авч үзвэл хот, суурин газрын 479.5 мянган өрхийн 87.9 хувь, хөдөөгийн 234.3 мянган өрхийн 84.8 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байна гэсэн үр дүн гарчээ.

ЗУРАГ 3.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, ХУВИАР, 2010 ОН



Зураг 3.2-оос харахад хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй 93 365 өрхийн 88.3 хувьд нэг, 10.5 хувьд хоёр, 1.2 хувьд гурав, түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

### ХҮСНЭГТ 3.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН АМ БҮЛ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХУВИАР, 2010 ОН

Өрхийн ам бүлийн тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй нийт		Өрхийн хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо					
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	1 хүнтэй		2 хүнтэй		3 ба түүнээс дээш хүнтэй	
			Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>93 365</b>	<b>100.0</b>	<b>82 417</b>	<b>88.3</b>	<b>9 841</b>	<b>10.5</b>	<b>1 107</b>	<b>1.2</b>
1-2	20 792	100.0	19 518	93.9	1 274	6.1	-	-
3-4	40 174	100.0	35 569	88.6	4 224	10.5	381	0.9
5-6	24 954	100.0	21 339	85.5	3 179	12.7	436	1.8
7+	7 445	100.0	5 991	80.5	1 164	15.6	290	3.9

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, 1-2 ам бүлтэй өрхийн 93.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй нэг, 6.1 хувь нь хоёр хүнтэй байна. Үүнээс харахад, улсын хэмжээнд хоёр ам бүлтэй, өрхийн хоёр гишүүн хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй 1 274 өрх байна гэсэн үг юм.

Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэхийн хэрээр хөгжлийн бэрхшээлтэй нэг хүнтэй өрхийн хувь буурч, хөгжлийн бэрхшээлтэй хоёроос дээш хүнтэй өрхийн тоо өссөн байлаа. Жишээлбэл, 5-6 ам бүлтэй өрхийн 85.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй нэг хүнтэй байсан бол энэ тоо 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн хувьд 5 пунктээр бага байв. Мөн 3-4 ам бүлтэй 10 өрх тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй 2 хүнтэй байсан бол харьцангуй олон буюу 7, түүнээс дээш ам бүлтэй 6 өрх тутмын бараг нэгд нь хөгжлийн бэрхшээлтэй 2 хүн тохиолдож байна гэсэн үр дүн гарчээ.

### 3.2. ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, ЗОРИУЛАЛТ БА ЭЗЭМШЛИЙН БАЙДАЛ

Монголчууд сууцны төрлийн хувьд эрт дээр үеэс уламжлагдан ирсэн сууцны өвөрмөц төрөл болох гэр болон бүх төрлийн байшин гэсэн үндсэн хоёр сууцад амьдарч байна. Үүний зэрэгцээ зориулалтын бус, цаашлаад сууцны хэв шинжийг агуулаагүй бусад хэлбэрийн сууцад ч амьдрах байдал цөөн боловч тохиолдсон.

### ЗУРАГ 3.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй 93.4 мянган өрхийн 50.8 хувь нь гэрт, 48.0 хувь нь байшинд амьдардаг бол 1.2 хувь нь болох нийт 1 155 өрх зориулалтын бус сууцад амьдарч байв. Үүнийг Монгол Улсын нийт өрхийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад гэрт амьдардаг өрхийн хувь 5.3 пунктээр өндөр, байшинд амьдардаг өрхийн хувь 5.6 пунктээр доогуур, зориулалтын бус сууцад амьдардаг өрхийн хувь ойролцоо байна.

### ХҮСНЭГТ 3.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Сууцны төрөл	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>93 365</b>	<b>100.0</b>	<b>57 837</b>	<b>100.0</b>	<b>35 528</b>	<b>100.0</b>
Гэр	47 442	50.8	22 340	38.6	25 102	70.7
Байшин	44 753	48.0	34 536	59.7	10 217	28.8
Зориулалтын бус сууц	1 155	1.2	947	1.7	208	0.5
Бусад	15	-	14	-	1	-

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн сууцны төрлийг байршлаар авч үзвэл хотод байшинд амьдардаг өрхийн хувь, хөдөөд гэрт амьдардаг өрхийн хувь өндөр гарсан байв. Тухайлбал, хот, суурин газарт оршин сууж буй хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй 5 өрх тутмын 3 нь байшинд амьдардаг бол хөдөөд энэ үзүүлэлт түүнээс 2 дахин бага төвшинд байна. Анхнаасаа хүн амьдрах зориулалтаар баригдаагүй боловч хүн амьдрахад зориулж зассан сууцад тооллогын үед амьдарч буй өрхийн тоо хотод хөдөөгөөс 1.2 пунктээр илүү байна.

### ХҮСНЭГТ 3.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЗОРИУЛАЛТ, ХУВИАР, 2010 ОН


Сууцны зориулалт	Нийт		Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>713 780</b>	<b>100.0</b>	<b>93 365</b>	<b>100.0</b>
Гэр	322 836	45.3	47 442	50.9
Зориулалтын бус сууц	8 064	1.1	1 155	1.2
Бусад	72	-	15	-
Байшин	382 808	53.6	44 753	47.9
Орон сууцны байшин	152 338	21.3	12 968	13.9
Бие даасан тохилог сууц	3 839	0.5	273	0.3
Сууцны тусдаа байшин	209 931	29.4	29 893	32.0
Оюутан, сурагчдын нийтийн байр	1 700	0.2	108	0.1
Ажиллагсдын нийтийн байр	10 344	1.5	1 036	1.1
Нийтийн зориулалтын бусад байр	4 656	0.7	475	0.5

Тооллогоор, сууцны төрлөөс гадна байшингийн төрөл гэсэн үзүүлэлтийг авч үзсэн бөгөөд байшинд амьдардаг нийт өрхийн дотор сууцны тусдаа байшин болон орон сууцны байшинд амьдардаг өрхүүд дийлэнх хувийг бүрдүүлсэн байв. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй нийт өрхийн 47.9 хувь, байшинд амьдардаг өрхийн 95.8 хувь нь дээрх 2 төрлийн байшинд амьдардаг ажээ.

Харьцангуй тохилог гэж хэлж болохуйц сууцууд болох орон сууцны байшин болон бие даасан тохилог сууцанд амьдардаг өрх нийт өрхийн 1/4 орчим хувийг эзэлж байсан бол хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхөд энэ тоо 10 орчим пунктээр доогуур байв. Түүнчлэн бусад төрлийн сууцад амьдардаг 72 өрх байсны 15 нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажээ.


Өрхийн амьдарч байгаа сууцны төрлөөс гадна тухайн сууцны эзэмшлийн байдал нь өрхийн аж байдлыг тодорхойлох чухал үзүүлэлт. Манай Улсын 713.8 мянган өрхийн 619.0 мянга нь буюу 86.7 хувь нь тооллогын үед өөрийн эзэмшлийн сууцдаа амьдарч байжээ. Сууцны эзэмшлийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн 89.7 хувь нь өөрийн эзэмшлийн сууцад, 10.3 хувь нь бусдын сууцад амьдардаг байна.

ЗУРАГ 3.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛЭЭР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, сумын төв болон хөдөөгийн өрхийн 94.1 хувь нь өөрийн эзэмшлийн сууцад амьдардаг бол нийслэл, аймгийн төв болон тосгоны өрхүүдийн 87.0 хувь нь өөрийн эзэмшлийн сууцад амьдардаг ажээ. Мөн хөдөөд бусдын сууцыг түрээслэн суух явдал харьцангуй бага тохиолддог буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн ердөө 1.2 хувь нь тооллогын үед бусдын сууцанд түрээс төлөн амьдарч байсан байна. Энэ нь хот суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт ах дүү, хамаатан садан гэх мэт нийгмийн хамаарал ихээхэн чухал хэвээр байгааг илэрхийлж байж болох талтай.


ЗУРАГ 3.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШИЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



Гэрт амьдардаг өрхийн 96.5 хувь нь сууцаа өөрийн эзэмшлийн хэмээн хариулсан нь бусад төрөлтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байв (Зураг 3.6). Энэ нь орон сууц, сууцны тусдаа байшин зэрэг сууцны төрөлтэй харьцуулахад гэр нь харьцангуй өртөг багатай байдаг учраас иргэд гэр барих, өвлөх, шинээр худалдан авах боломж илүү байдагтай холбоотой болов уу.

Орон сууцны байшин, тохилог сууц, сууцны тусдаа байшин, нийтийн эзэмшлийн байр зэрэг бүх төрлийн байшинд амьдарч байгаа өрхүүдийн 3.1 хувь нь тухайн сууцдаа зохих хэмжээний түрээс төлөн суудаг бөгөөд хашаа байшин болон орон сууцыг түрээслэн суух явдал түгээмэл байдаг ажээ.

ЗУРАГ 3.6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО,  
СУУЦНЫ ЭЗЭМШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХУВИАР, 2010 ОН



\*Тайлбар: Бусад гэсэн сууцад амьдардаг өрхүүдийн тоо цөөн тул хасаж тооцов.

Зориулалтын бус сууцад амьдарч байгаа өрхүүдийн тухайн сууцаа эзэмшиж байгаа хувь хамгийн бага, тэрхүү сууцдаа түрээс төлөлгүй амьдарч байгаа байдал хамгийн өндөр хувийг эзэлж байв. Ийм төрлийн сууцанд амьдарч байгаа 4 өрх тутмын нэг нь тухайн сууцдаа түрээс төлдөггүй байна. Үүний зэрэгцээ хүн амьдрах зориулалтаар баригдаагүй сууцанд түрээс төлөн амьдрах тохиолдол хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн хувьд цөөн боловч тохиолджээ (20 өрх).

### 3.3. АХУЙН НӨХЦЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн амьдарч буй сууцаас гадна усан хангамж, цахилгаан, дулааны эх үүсвэр зэрэг нь ахуйн нөхцлийг тодорхойлох чухал үзүүлэлт байдаг. Улсын хэмжээнд нийтийн зориулалтын бусад байрнаас бусад төрлийн байшинд амьдардаг өрхийн 42.8 хувь нь төвлөрсөн системээр, 0.4 хувь нь бие даасан системээр, 56.8 хувь нь зөөврийн байдлаар ундны усны хэрэгцээгээ хангадаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн хувьд төвлөрсөн усан хангамжтай өрхийн хувь улсын дунджаас 11.6 пунктээр доогуур, зөөврийн усан хангамжтай өрхийн хувь улсын дунджаас 11.7 пунктээр өндөр байв.

ЗУРАГ 3.7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО,  
УСАН ХАНГАМЖИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН



\*Тайлбар: Нийтийн зориулалтын бусад байранд амьдардаг өрхөд хамаарахгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, байшинд амьдардаг нийт 44 278 өрх байгаагийн 68.5 хувь нь зөөврийн усан хангамжтай бөгөөд ялангуяа, сууцны тусдаа байшин, ажиллагчдын нийтийн байранд амьдардаг өрхүүдийн дунд ундны усаа зөөж хэрэглэх тохиолдол түгээмэл байна.

Харин орон сууцны байшин, бие даасан тохилог сууц зэрэг байшинд амьдарч байгаа өрхийн 90-ээс илүү хувь нь төвлөрсөн усан хангамжаас ундны усныхаа хэрэгцээг хангадаг байна.

#### ХҮСНЭГТ 3.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН

Байшингийн төрөл	Байшинд амьдардаг		Усан хангамжийн төрөл (хувь)		
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Төвлөрсөн систем	Бие даасан систем	Зөөврийн
<b>БҮГД</b>	<b>44 278</b>	<b>100.0</b>	<b>31.2</b>	<b>0.3</b>	<b>68.5</b>
Орон сууцны байшин	12 968	100.0	99.9	0.1	-
Бие даасан тохилог сууц	273	100.0	91.6	8.4	-
Сууцны тусдаа байшин	29 893	100.0	1.0	0.3	98.7
Оюутан, сурагчдын нийтийн байр	108	100.0	59.3	-	40.7
Ажиллагчдын нийтийн байр	1 036	100.0	24.5	0.7	74.8

\*Тайлбар: Нийтийн зориулалтын бусад байранд амьдардаг өрхөд хамаарахгүй

Улсын дунджаар 4 өрх тутмын 3 нь буюу 76.6 хувь нь эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон, 3.3 хувь нь цахилгааны эх үүсвэргүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн 95.3 хувь нь төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж зэргийн аль нэгийг ашиглан эрчим хүчний хэрэгцээгээ хангадаг бол 4.7 хувь нь цахилгаан эх үүсвэргүй байна.

#### ЗУРАГ 3.8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНТЭЙ ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2010 ОН



Цахилгааны эх үүсвэр нь хот, хөдөөд ялгаатай байв. Хотын нийт өрхийн 93.9 хувь нь эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон бол хөдөөгийн өрхүүдийн 40.6 хувь нь төвлөрсөн системд холбогдсон ба хөдөөгийн өрхүүд сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглан эрчим хүчний асуудлыг шийдвэрлэх нь түгээмэл байна.

### ХҮСНЭГТ 3.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Цахилгааны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>93 365</b>	<b>100.0</b>	<b>57 837</b>	<b>100.0</b>	<b>35 528</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	68 722	73.6	54 297	93.9	14 425	40.6
Дизель станц	2 536	2.7	1 222	2.1	1 314	3.7
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	15 978	17.1	962	1.7	15 016	42.3
Бага оврын цахилгаан үүсгүүр	1 723	1.8	349	0.6	1 374	3.9
Цахилгаан эх үүсвэргүй	4 406	4.8	1 007	1.7	3 399	9.5

Үүний зэрэгцээ хөдөө орон нутагт 10 өрхийн нэг нь цахилгааны эх үүсвэргүй байна. Өмнөх бүлэгт дурьдсанчлан мэдээлэл харилцаа холбооны хэрэгслийн хэрэглээ доогуур гарахад нөлөөлсөн нэг хүчин зүйл нь энэ юм. Түүнчлэн төв суурин газар амьдардаг хэдий ч цахилгааны эх үүсвэргүй өрх цөөн боловч байгаа нь өнөөгийн нийгэмд анхаарал татсан үзүүлэлт мөн.

Эрс тэс уур амьсгалтай манай орны нөхцөлд гэрт амьдардаг, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй 47 442 өрхийн дулааны эх үүсвэр ердийн галлагаа бөгөөд байшинд амьдардаг 44 753 өрхийн хувьд ч ердийн галлагаа зонхилсон хандлагатай байв.

### ЗУРАГ 3.9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, байшинд амьдарч байгаа өрхийн талаас илүү хувь нь ердийн галлагаатай сууцад амьдардаг бөгөөд үүний дараагаар төвлөрсөн дулаанд холбогдсон өрхүүд орж байна.


### ХҮСНЭГТ 3.6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ, БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР, 2010 ОН

Улсын дунджаар байшинд амьдардаг өрхийн 50.2 хувь нь ердийн галлагаатай сууцад амьдардаг байхад хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн хувьд уг үзүүлэлт 10 орчим пунктээр илүү байв. Өөрөөр хэлбэл, өвлийн улиралд гал түлэх, нүүрс, түлээ бэлтгэх зэрэг ахуйн нөхцлийн тулгамдсан асуудал хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхөд илүүтэй тохиолдож байна. Ажиллагсдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байр зэрэг байшинд амьдарч буй өрхүүдийн хувьд төвлөрсөн халаалтгүй буюу ахуйн нөхцлийн хувьд хангалтгүй байх нь элбэг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй байшинд амьдардаг нийт өрхийн 30.8 хувь нь сууцны дотор, 66.0 хувь нь сууцны гадна бие засах газартай байхад 3.2 хувь нь буюу нийт 1 402 өрх тогтсон бие засах газаргүй байв. Ийнхүү сууцны гадна бие засах газартай өрхийн хувь харьцангуй өндөр байгаа нь байшинд амьдардаг өрхүүдийн дийлэнхийг сууцны тусдаа байшинд буюу гэр хорооллын хашаа, байшинд амьдардаг өрхүүд эзэлж байгаатай холбоотой юм.

Орон сууцны байшин болон тохилог сууцанд амьдардаг бүх өрх, оюутан, сурагчдын нийтийн байранд амьдардаг өрхүүдийн 57.4 хувь, бусад төрлийн нийтийн байранд амьдардаг өрхүүдийн 20 орчим хувь нь тус тус сууцны дотор бие засах газартай байсан бол сууцны тусдаа байшинд амьдардаг өрхүүдийн 95.1 хувь нь сууцны гадна бие засах газартай байв. Үүнээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнх нь сууцны гадна, цаашлаад тэдэнд зориулагдаагүй бие засах газартай байгаа нь ахуйн нөхцлийн наад захын хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байгааг харуулж байна.

**ЗУРАГ 3.10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ, БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, БИЕ ЗАСАХ ГАЗАРТАЙ ЭСЭХ, ХУВИАР, 2010 ОН**



Хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэр нь өрхийн ахуйн нөхцлийн төдийгүй эрүүл аж төрөх орчин ахуйн үзүүлэлтийн нэг юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн 55.9 хувь нь үйлчилгээний байгууллагаар буюу зориулалтын цэгт хатуу хог хаягдлаа зайлуулдаг бол 21.6 хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон газаргүй байна.

**ЗУРАГ 3.11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, ХОГ, ХАЯГДЛАА ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН**






Байшинд амьдардаг өрхийн 71.2 хувь нь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулдаг бол 21.2 хувь нь зөвшөөрөгдсөн цэгт хаядаг, харин бусад сууцны төрөлтэй харьцуулахад хамгийн бага буюу 7.6 хувь нь тогтсон газар байхгүй гэжээ (Зураг 3.12).

Харин гэрт амьдардаг өрхийн 35 орчим хувь нь тооллогын үед хатуу хот хаягдлаа зайлуулах тогтсон газаргүй байгаа нь хог хаягдлын асуудал нь гэр хороолол дахь тулгамдсан асуудал хэвээр байгааг илэрхийлж байна.

**ЗУРАГ 3.12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНТЭЙ БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАТУУ ХОГ ХАЯГДЛАА ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН**



Байнгын бус, хүн амьдрахад тохиромжгүй, түр орогнох орон сууцад амьдарч буй өрхийн 20 хувь нь хатуу хот, хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг гэсэн хариултыг өгсөн бөгөөд дийлэнх нь орцны жижүүр хийж орцонд амьдардаг айлууд байв. Харин “бусад” гэсэн ангилалд багтах сууцад амьдарч буй 4 өрх тутмын 3 нь хатуу хог хаягдал зайлуулах тогтсон газаргүйн улмаас хог хаягдлаа ил задгай хаяж, орчин ахуйг бохирдуулдаг байна.



## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ





## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### ДҮГНЭЛТ

Монгол Улсад бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас жирийн иргэдийн адил нийгмийн харилцаанд орох боломж нь бүрмөсөн болон түр хязгаарлагдсан нийт 108 071 иргэн байгаа нь суурин хүн амын 4.1 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 3 хүн тутмын нэг нь төрөлхийн, 2 нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь манай улсын хүн амын дунд өвчлөл, гадны шалтгаант эмгэг согог, осол, гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлд өртөх эрсдэл илүү байгааг харуулж байна. Үүнтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлийн илрэх хэлбэрээс түгээмэл нь хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл байв. Иймээс цаашид олдмол хөгжлийн бэрхшээлийн шалтгааныг нарийвчлан судалсны үндсэн дээр түүнээс урьдчилан сэргийлэх, улмаар хөгжлийн бэрхшээлийн тохиолдлыг бууруулах боломж байгаа нь харагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын тоо эмэгтэй хүн амын тооноос илүү байгаа хандлага 70 хүртэлх бүх насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрийн аль алинд ажиглагдаж байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хүйсийн харьцаа 103, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хүйсийн харьцаа 136 байгаа нь эрүүл төрсөн хэдий ч амьдралын явцад хөгжлийн бэрхшээлд өртсөн байдал эрэгтэйчүүдийн дотор илүү байгааг илтгэнэ. Энэ нь нэг талаар хоол хүнс, архи, тамхины зохисгүй хэрэглээ осол, гэмтэлд өртөх эрсдэл эрэгтэйчүүдэд харьцангуй илүү тохиолддогтой холбоотой.

Төрөлхийн бэрхшээлийн тохиолдол залуу насны хүн амд түгээмэл байснаа хүн амын нас ахихын хэрээр олдмол бэрхшээлд өртсөн иргэдийн хувь өссөн явдал нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас харьцангуй залуу, харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас хөгшин гарахад нөлөөлсөн. Эхээс хөгжлийн бэрхшээлтэй төрсөн, тооллогын үед амьд байсан хүн амын 1/2 нь 30 хүртэлх, 1/2 нь түүнээс дээш насныхан байв. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын голч нас үүнээс 16 жилээр урт байлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхэд тутмын 6-7 нь ерөнхий боловсролын сургуульд элсэн орж, 4-р анги хүртлээ суралцаж байгаад дунд ангид ороход тэдний 1-2 нь, ахлах ангид мөн л 1-2 нь сургуулиас завсардсанаар тэд бага, суурь цаашлаад бүрэн дунд боловсролыг эзэмшиж чадахгүйд хүрч байна. Эдгээр хүүхдүүд нас ахих тутам сургуульд суралцах нь багасаж байгаа нь ичиж зовох, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцохоос айж эмээх гэх мэт шалтгаантай холбоотой байж болох тул үүнийг цаашид гүнзгийрүүлэн судлах бодит хэрэгцээ байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд суралцах хүсэл, эрмэлзэл байвч манай улсад эдгээр иргэд саадгүй чөлөөтэй зорчих гудамж талбай, зам, нийтийн тээвэр, барилга байгууламж, сургалтын материаллаг орчин хангалтгүй байгаа явдал нь тэдний суралцах эрхийг хязгаарлаж, нийгэмд боловсролгүй, “үл үзэгдэгч” байдлаар амьдрах нөхцлийг бүрдүүлсээр байна.

Эдийн засгийн идэвхгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хөдөлмөр эрхлэх чадваргүй гэсэн шалтгаан зонхилсон нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие махбодь, оюун ухаан, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн эмгэгийн улмаас нийгмийн амьдралд оролцох боломжоор хязгаарлагдаж байгаагийн бодит илрэл болж байна. Мөн ажил эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хувиараа хөдөлмөр эрхлэх, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцох байдал өндөр, эсрэгээр цалин хөлстэй ажиллах байдал доогуур байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх орчин, нийгэм сэтгэл зүйн уур амьсгал бүрдээгүй болохыг харуулж байна.

Арван тав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын талаас илүү хувь нь гэр бүлтэй байгаа нь төдийлөн доогуурт тооцогдох үзүүлэлт биш юм. Хөгжлийн бэрхшээлийн тохиолдол нийт өрхийн дунд ямар байгааг авч үзвэл 13 өрх тутмын нэгд нь хөгжлийн бэрхшээлтэй нэг, түүнээс дээш тооны хүн амьдарч байгаа ба эдгээр өрхүүдийн ус,

цахилгаан, халаалт зэрэг ахуйн нөхцлийн үзүүлэлт нь улсын дунджаас доогуур, анхаарал татсан төвшинд байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд нийгмийн амьдралд оролцох боломжоор хязгаарлагдмал аж төрөхийн зэрэгцээ цахилгаан, дулаан, халуун усны хангамж, бие засах газар, хог хаягдал зайлуулалт гэх мэт дэд байгууламжийн хувьд шаардлага хангахгүй нөхцөлд амьдарч буй байдал илүүтэй байгааг харуулж байна.

## ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик мэдээллийг сайжруулах хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөл байдлыг бодитойгоор үнэлж дүгнэх, шаардлагатай бодлого, арга хэмжээг оновчтой төлөвлөхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бүртгэл, мэдээллийг сайжруулах, статистик мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байршил, төрөлт, нас баралт, дундаж наслалт, ажил эрхлэлт, боловсролын үйлчилгээнд хамрагдалт зэрэг хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдээр гаргаж, олон нийтэд хүртээмжтэй болгох;

Дэлхий дахинаа хөгжлийн бэрхшээлийг нийгэм, эдийн засаг, соёл, хүний эрхийн талаас авч үзэж буй өнөө үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдал, амьдралын хэв маяг, эрхээ эдэлж буй байдал, ялгаварлан гадуурхалтанд өртөх эрсдэл, итгэл үнэмшил зэргийг тодруулсан суурь болон хавсарга, цаашлаад мониторингийн судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг бодлогын төвшинд хөхүүлэн дэмжих;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар үндэсний болон аймаг, орон нутгийн төвшинд нэгдсэн мэдээллийн сүлжээ бий болгох, түүнд тогтмол шинэчлэл хийж, мэдээллийн чанар, найдвартай байдал, аюулгүй байдлыг ханган ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх, цахим хуудас нээж ажиллуулах;

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд:**

Монгол Улс нь НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” конвенцэд нэгдэн орсон орны хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэднийг нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг дээшлүүлэх бүхий л үйл ажиллагаанд оролцогч талын түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавих, энэ хүрээнд ажиллаж буй төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, тэдний эрх ашгийг хамгаалан ажилладаг төрийн бус байгууллагыг өргөнөөр оролцуулах;

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулах хүрээнд:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг дээшлүүлэхийн тулд тэдэнд зориулсан дэд бүтцийг сайжруулахад онцгой анхаарах, энэ чиглэлийн үйлдвэрлэгчдийг дэмжих, тэдэнд зориулсан татвар, зээл, санхүүгийн бусад хөшүүрэг бий болгох;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулах чиглэлээр, нийгмийн хариуцлагынхаа хүрээнд бүтээн байгуулалтын ажил санаачлан хэрэгжүүлсэн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, бусад дэмжлэгийн механизмыг бий болгох;

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд:**

Сургууль, цэцэрлэгийн орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй хэлбэрээр засч тохижуулах, сургалтын бааз, хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг бодлогын төвшинд зохион байгуулж хэрэгжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурч хүмүүжихэд зориулсан сургалтын тусгай хөтөлбөр боловсруулах, шаардлагатай сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, хэрэгжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлах боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, тэдний хөдөлмөрийн нөхцөл, цалин, урамшууллыг боловсронгуй болгох, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах;

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд:**

